

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

2024 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛ



АГУУЛГА

I. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны
зах зээл

8

ХАА-н гаралтай
бараа, түүхий
эдийн зах зээл

14

Биржийн
бус зах зээл

15

Уул уурхайн
бүтээгдэхүүний
зах зээл

16

Ашигт
ажиллагаа

18

Тогтвортой
байдал

22

Бодлого
зохицуулалт

23

II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах
зээлийн төлөв

28

Хүртээмжтэй
байдал

32

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

35

Ашигт
ажиллагаа

37

Тогтвортой
байдал

38

Бодлого
зохицуулалт

39

III. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн зах
зээлийн төлөв

44

Хүртээмжтэй
байдал

49

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

52

Ашигт
ажиллагаа

55

Тогтвортой
байдал

57

Финтек ба
ногоон зээл

59

Бодлого
зохицуулалт

62

IV. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зах
зээлийн төлөв

66

Хүртээмжтэй
байдал

68

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

72

Ашигт
ажиллагаа

76

Тогтвортой
байдал

78

Бодлого
зохицуулалт

80

V. МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

Санхүүгийн зах
зээлийн төлөв

86

Хүртээмжтэй
байдал

88

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

89

Ашигт
ажиллагаа

90

Бодлого
зохицуулалт

91

VI. ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Санхүүгийн зах
зээлийн төлөв

94

Хүртээмжтэй
байдал

95

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

97

Ашигт
ажиллагаа

99

Тогтвортой
байдал

100

VII. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ

Салбарын
төлөв

104

Ашигт
ажиллагаа

106

Хүртээмжтэй
байдал

107

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

108

Тогтвортой
байдал

109

Бодлого
зохицуулалт

112

VIII. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

Салбарын
төлөв

116

Хүртээмжтэй
байдал

117

Бүтээгдэхүүн
үйлчилгээ

118

Ашигт
ажиллагаа

119

Бодлого
зохицуулалт

120

IX. СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Сэндбоксад туршигдаж буй
бүтээгдэхүүнүүд

124

Бодлого
зохицуулалт

131

X. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Салбарын төлөв

134

Хүртээмжтэй
байдал

135

Бүтээгдэхүүн
үйлчилгээ







136

Ашигт
ажиллагаа

137

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж	ҮЦК	Үнэт цаасны компани
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
АХБ	Азийн хөгжлийн банк	ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ГҮТББ	Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага	ХК	Хувьцаат компани
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч	ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр	ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗМС	Зээлийн мэдээллийн сан	ХХААДЗ	Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл
МЗҮАЭ	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч	ФБ	Фэйсбүүк
МИК	Монголын ипотекийн корпораци	ТОС	Тогтвортой санхүүжилт
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	АFI	Alliance for Financial Inclusion /Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх	IPO	Initial public offering /Олон нийтэд хувьцаагаа санал болгох/
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага	GIZ	German corporation for int. Cooperation
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл	MSE	Mongolian stock exchange /Монголын хөрөнгийн бирж/
СМА	Санхүүгийн мэдээллийн алба	P2P	Peer to peer
ТДЦА	Татварын дараах цэвэр ашиг	QR	Quick response code
ТЗК	Тусгай зориулалтын компани	ROE	Return on equity
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал	ROA	Return on assets
ҮХЭХЗБ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага	UNEP FI	Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтийн санаачилга
ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч		
ҮСХ	Үндэсний статистикийн хороо		

 <p>ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ</p>	Зах зээлийн үнэлгээ 11,305.7 тэрбум төгрөг ЗЗҮ/ДНБ 16.0%	Нийт хөрөнгө 616.6 тэрбум төгрөг	ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ 	
	ТОП-20 индекс 44,385.18	Арилжааны дүн 850.7 тэрбум төгрөг	Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж 222.1 тэрбум төгрөг	Даатгалын нөхөн төлбөр 70.0 тэрбум төгрөг
ҮЦК-ийн тоо 52	Хөрвөх чадвар 1.4%	Цэвэр ашиг 19.8 тэрбум төгрөг	Нөөц сан 290.6 тэрбум төгрөг	
MSE A 17,223.73 MSE B 13,387.44	Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хэмжээ 6,155.3 тэрбум төгрөг	Гүнзгийрэлт 0.32%	Нягтрал 115,405 төгрөг Давхар даатгалын хураамжийн зардал 57.0 тэрбум төгрөг	
 <p>БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА</p>	Тусгай зөвшөөрөлтэй 549 ББСБ	88.5 % Зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй	Тусгай зөвшөөрөлтэй 181 ХЗХ	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО 
	Нийт хөрөнгө 5.8 их наяд төгрөг	4.9 сая Харилцагч	Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2.8%	74,186 гишүүн
Нийт зээл 4.6 их наяд төгрөг	Нийт зээлдэгч 1.9 сая	Нийт хөрөнгө 327.8 тэрбум төгрөг	Цэвэр ашиг 5.8 тэрбум төгрөг	НИЙТ ЗЭЭЛ 243.3 тэрбум төгрөг
Зээлийн жигнэсэн дундаж хүү 3.5%	Нийт орлого 800.9 тэрбум төгрөг Хүүгийн орлого 712.9 тэрбум төгрөг	2.3% Зээлийн жигнэсэн дундаж хүү	1.3% Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү	
 <p>ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ</p>	ҮХЭХЗ-ын байгууллага 311	Иргэн 453	Хуулийн этгээд 53	ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ 
	Зуучлан худалдсан 1,268.2 тэрбум төгрөг	Зуучлан түрээслүүлсэн 103.2 тэрбум төгрөг	Үнэт металл худалдан авалт 148.2 тэрбум төгрөг	Үнэт металлын борлуулалт 144.6 тэрбум төгрөг



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн үнэлгээ

11,305.7
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Дансны тоо
2,594,155



Хүртээмжтэй байдал

Нийт арилжааны дүн
850.7 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



ҮЦК-ийн хөрөнгө

221.8

тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ
(ҮЦК, ХОМК)

3.9

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Төвлөрөл

33Ү-ний **69.8** хувийг
Топ-10 ХК

Бодлого зохицуулалт



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд **НИЙТ 608** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа эрхэлж байна

Хувийн хөрөнгө оруулалтын сан (Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 5.3 дахь заалт)

39

Мэргэжлийн холбоо, өөрийгөө зохицуулах байгууллага

1

Дэд бүтцийн байгууллага

Арилжаа эрхлэх байгууллага 3	Үнэт цаасны тооцооны байгууллага 2 /1 давхардсан/	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага 1
Үнэт цаасны төлбөрийн байгууллага 1 /давхардсан/	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж 1 /давхардсан/	ХАА-н бирж 1

Мэргэжлийн оролцогч

ҮЦК 52	ХОМК 33	Хамтын хөрөнгө оруулалтын сан 6
Кастодиан банк 3	Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк 2	ХАА-н түүхий эдийн брокер 9
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч 7 /давхардсан/		Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага 3

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч 63 /ТЗК/	Хөрөнгө итгэмжлэн удирдах 8	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагч 1
---	---------------------------------------	--

Бүртгэлтэй этгээд

ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх 52 /8 давхардсан/	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 23 /давхардсан/	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 44
ХК 311		

Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй – 172 ХК


Улаанбаатар үнэт цаасны биржэд бүртгэлтэй – 2 ХК

*ҮЦК-д брокер, дилер, андеррайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамруулна.

Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- Тайлант улиралд 850.7 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 57.8 хувиар, 2020 оны мөн үеэс 29.2 дахин өссөн үзүүлэлт юм.
- Нийт арилжааны 21.9 хувийг хувьцааны, 4.5 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 66.4 хувийг компанийн бондын, 7.2 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.



Үнэт цаасны арилжаа /тэрбум төгрөг/



ХОС-ийн 2023 оны 1 дүгээр улирлын нэгж эрхийн арилжааны тайланд өөрчлөлт орсон болно.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Тайлант улиралд зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өсөж 11,305.7 тэрбум төгрөгт хүрсэн бол хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 1.4 хувь байна.



ТОП 20 **44,385.18**

MSE A **17,233.73**

MSE B **13,387.44**

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,486.02 нэгжээр буюу 20.3 хувиар өссөн.
- MSE A индекс өмнөх оны мөн үеэс 1,007.50 нэгжээр буюу 6.2 хувиар өссөн.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 1,208.83 нэгжээр буюу 9.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ



ТОП-20 индексийн багцыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал гэсэн шалгуур үзүүлэлтэд үндэслэн бүрдүүлдэг. 2024 оны 2 дугаар улиралд бүртгэлтэй компаниудын 15.5 хувийг банк санхүүгийн салбар бүрдүүлж байгаа бол ТОП-20 индексийн багцын 61.0 хувийг тус салбар эзэлж байна

ТОП-20 ИНДЕКСТ БАГТАХ ХК-УУДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ /ЗЗҮ-ЭЭР/





ҮЦТХТ-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС



ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж дээр идэвхтэй арилжаа явуулдаг 169 ХК-ийн хувьцааны төвлөрлийг 5-аас дээш болон түүнээс доош хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн тоогоор доор хүснэгтэд харуулав.



ХУВЬЦААНЫ ӨМЧИЙН БҮТЭЦ


- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 311 ХК-ийн өмчийн бүтцийг задлан харвал 89.4 хувь нь хувийн өмчит, 6.7 хувь нь төрийн өмчит, 3.9 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байна.

ҮНЭТ ЦААСНЫ ДАНСНЫ ТОО

- Шинээр 200,861 данс нээгдэж нийт дансны тоо 2,594,155-т хүрсэн бол 66,804 холболтын данс нээгдэж нийт 657,266-т хүрлээ.


НЭЭГДСЭН ДАНСНЫ ТОО

■ Холболтын данс ■ Шинэ данс



ДАНСНЫ ТОО
/ӨССӨН ДҮНГЭЭР/

2,594,155



АРИЛЖААНЫ БҮТЭЦ /үнийн дүнгээр/

- Арилжаанд оролцогчдын дийлэнх хувь буюу 74.2 хувийг Дотоодын ААН-н хийсэн гүйлгээ эзэлж байгаа нь тэдний хөрөнгийн зах зээлийн идэвхжилт өндөр байгааг харуулж байна. Харин дотоодын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 24.6 хувийг, гадаадын иргэний хийсэн арилжааны гүйлгээ 0.9 хувийг, гадаадын ААН-ийн хийсэн арилжааны гүйлгээ 0.3 хувийг тус тус эзэлж байна.

АРИЛЖААНД ОРОЛЦОГЧИЙН ТОО, ДАВТАМЖ /ӨССӨН ДҮНГЭЭР/


- Арилжаанд давтагдсан тоогоор нийт 64,240 иргэн, 1,275 ААН оролцож, 165,307 удаагийн арилжаа хийсэн байна. Хөрөнгө оруулагчдын 97.3 хувийг дотоодын иргэн, 1.9 хувийг дотоодын ААН, 0.7 хувийг гадаадын иргэн, 0.1 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.



	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо /давхардсан/	
ГАДААДЫН ААН	43	0.1%	231	0.1%
ГАДААДЫН ИРГЭН	478	0.7%	1,974	1.2%
ДОТООДЫН ААН	1,232	1.9%	10,543	6.4%
ДОТООДЫН ИРГЭН	63,762	97.3%	152,559	92.3%
НИЙТ	65,515	100.0%	165,307	100.0%


ҮЦК БАЙРШИЛ

- Улаанбаатар хотод 52 ҮЦК үйл ажиллагаа эрхэлж байна.



ҮЦК-ИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАЙРШИЛ

- ҮЦК-ийн 37 салбар, төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж буйгаас 36 нь орон нутагт, 1 нь Улаанбаатар хотод байршиж байна.



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Нийт хувьцааны арилжаа 185.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.7 хувиар буурч, 2020 оны мөн үетэй харьцуулахад 7.9 дахин өсжээ.




ШИНЭЭР ГАРГАСАН ХУВЬЦАА /IPO/

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Олон нийтээс татан төвлөрүүлсэн дүн
"Эм Жи Эл Акуа" ХК	2024.04.29	15.2 тэрбум төгрөг

КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

- Компанийн бондын арилжаа 565.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.1 дахин, 2020 оны мөн үетэй харьцуулахад 113.0 дахин өсжээ. Нийт бондын арилжааны 88.5 хувийг "Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд" гаргасан өрийн хэрэгсэл эзэлж байна.




ШИНЭЭР ГАРГАСАН КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖАА

Гаргасан компани	Бүртгэсэн огноо	Өрийн хэрэгслийн дүн
"Ашид капитал ББСБ" ХХК	2023.02.23	20.0 тэрбум төгрөг
"Нийслэлийн Засаг даргын хөтөлбөрийн хүрээнд"	2024.06.05	500.0 тэрбум төгрөг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АРИЛЖАА


- Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа 38.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.0 хувиар өсжээ.



ХОС-ийн 2023 оны 1 дүгээр улирлын нэгж эрхийн арилжааны тайланд өөрчлөлт орсон болно.


ХӨДӨӨ АЖ АХУЙН БРОКЕРЫН КОМПАНИУДЫН БАЙРШИЛ

- 9 ХАА-ын брокер үйл ажиллагаа явуулж байгаагийн 7 нь Улаанбаатар хотод, 2 нь орон нутагт байршиж байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улиралд биржийн бус зах зээлд нийт 53 үнэт цаас гаргагчийн, 62 өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс 714.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдэж бодитоор 708.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Мөн доллароор 23.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэж, 8.9 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлжээ.



Биржийн бус зах зээлийн арилжаа 2021 оны 9 сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаа эхэлснээс хойш 3,163.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг бүртгэж, 2,449.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Мөн доллароор 94.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэж, 54.4 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлжээ. Нийт 565.2 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, амжилттай эргэн төлсөн байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоонд бүртгэлтэй биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрхтэй бүртгэлтэй шууд оролцогч нийт 30 байна. Үүнээс Андеррайтер 19, Дилер 25, Брокер 29, хөрөнгө оруулалтын сан 1 компани байна. Харин шууд оролцогч нарт бүртгэлтэй шууд бус оролцогч хувь хүн 2719, хуулийн этгээд 290 байна.

АНДЕРРАЙТЕР
19

ДИЛЕР
25



БРОКЕР
29

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САН
19

ХУВЬ ХҮН
2,719

ХУУЛИЙН ЭТГЭЭД
290

2024 ОНЫ 2-Р УЛИРЛЫН БАЙДЛААР БҮРТГЭГДСЭН БОНДЫН САЛБАРЫН АНГИЛАЛ




ЖИГНЭСЭН ДУНДАЖ ХҮҮ /ХУГАЦААГААР/

Нийт төгрөгөөр бүртгэгдсэн бондын нийт дундаж дундаж хүү 19.5 хувь байна. Үүнээс 24 сарын хугацаатай бонд 19.7 хувь, 18 сарын хугацаатай бонд 19.1 хувь, 12 сарын хугацаатай бонд 19.6 хувь байна.


БОНДЫН ХУГАЦАА /ТРАНЧААР/

Бондын хугацаа 12 сарын хугацаатай бонд 49% хувь, 18 сарын хугацаатай бонд 28%, 24 сарын хугацаатай бонд 14%, 36 сарын хугацаатай бонд 9%-ийг тус тус бүрдүүлээ.



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ


2024 оны 2 дугаар улирлын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 339 удаагийн арилжаагаар 15.5 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжлаа. Нийт 6,155.3 тэрбум төгрөгийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 5.0 дахин өссөн үзүүлэлт юм.



Нийт арилжааны 95.3 хувийг нүүрсний арилжаа, 3.9 хувийг төмрийн хүдэр, баяжмалын арилжаа, 0.7 хувийг зэсийн баяжмалын арилжаа, 0.1 хувийг хайлуур жоншны арилжаа тус тус эзэлж байна.

Бүтээгдэхүүний төрөл	Багцын тоо	Хэмжээ /мянган тонн/	Нийт үнийн дүн /тэрбум төгрөгөөр/
Нүүрс	2,274	14,553.6	5,867.6
Төмрийн хүдэр, баяжмал	304	980.1	241.9
Хайлуур жоншны баяжмал	67	4.4	5.3
Зэсийн баяжмал	6	6.0	40.5
Нийт	2,651	15,543.5	6,155.3


Нийт 339 удаагийн арилжаанд БНХАУ 252 удаа, Сингапур улс 46 удаа, ХонгКонг 39 удаа, Америк болон Монгол улс тус бүр 1,1 удаа оролцжээ.



НҮҮРСНИЙ АРИЛЖАА

Нийт 2,274 багц буюу 14,553.6 мянган тонн нүүрсийг арилжааны 5,867.5 тэрбум төгрөгөөр арилжлаа. Үүнээс “Эрдэнэс таван толгой” ХК 10,777.6 мянган тонн нүүрсийг 4,208.9 тэрбум төгрөгөөр, “Тавантолгой” ХХК 627.2 мянган тонн нүүрсийг 300.0 тэрбум төгрөгөөр, “Энержи ресурс” ХХК 3,065.6 мянган тонн нүүрсийг 1,323.3 тэрбум төгрөгөөр, “Хангад эксплорэйшн” ХХК 51.2 мянган тонн нүүрсийг 23.6 тэрбум төгрөгөөр, “Монгол Алт (МАК)” ХХК 32.0 мянган тонн нүүрсийг 11.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

- 1/3 коксжих нүүрс
- Баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрс
- Баяжуулсан коксжих нүүрс
- Баяжуулсан сул коксжих нүүрс
- Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс
- Эрчим хүчний нүүрс




Нийт арилжааны 40.5 хувийг 1/3 коксжих нүүрс, 32.1 хувийг дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс, 17.5 хувийг баяжуулсан коксжих нүүрс, 5.1 хувийг баяжуулсан дунд зэрэг үнстэй, хагас хатуу коксжих нүүрс, 4.5 хувийг эрчим хүчний нүүрс, 0.4 хувийг баяжуулсан сул коксжих нүүрс тус тус эзэлж байна.

ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Нийт 304 багц буюу 980.1 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 241.9 тэрбум төгрөгөөр арилжлаа. Үүнээс “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК 485.1 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 106.2 тэрбум төгрөгөөр, “Монголросцветмет” ТӨҮГ 195.0 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 135.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.


- Fe-52% Төмрийн хүдэр
- Fe-58% Төмрийн баяжмал
- Fe-65% Төмрийн баяжмал



ЗЭС БАЯЖМАЛ, ХАЙЛУУР ЖОНШНЫ БАЯЖМАЛЫН АРИЛЖАА

Нийт 6 багц буюу 6.0 мянган тонн 22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмалыг “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 40.5 тэрбум төгрөгөөр, 67 багц буюу 4.4 мянган тонн CaF₂-95% Хайлуур жоншны баяжмалыг “Монголросцветмет” ТӨҮГ нь 5.3 тэрбум төгрөгөөр тус тус арилжлаа.

АШИГТ АЖИЛЛАГАА




ҮЦК-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА


- Тайлант улиралд ҮЦК-уудын нийт хөрөнгө 221.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 20.7 тэрбум төгрөгөөр өсөж зарлага 11.7 тэрбум төгрөгөөр өсөж 14.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

ҮЦК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

● Брокерын үйл ажиллагааны орлого	25.8%
● Дилерийн үйл ажиллагааны орлого	9.6%
● Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	38.1%
● Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	4.3%
● Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	2.1%
● Бусад үйл ажиллагааны орлого	0.5%
● Түрээсийн орлого	0.1%
● Хүүний орлого	13.0%
● Ногдол ашгийн орлого	3.0%
● Бусад орлого	0.9%
● Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.7%
● Бусад ашиг	1.9%



ҮЦК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ




- Борлуулалтын маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Бусад зардал
- Орлогын татварын зардал
- Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого

ҮЦҚ-УУДЫН УЛСАД ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, НДШ



- Үнэт цаасны компаниуд 2024 оын 2 дугаар улирлын байдлаар НДШ-д 1.9 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.3 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 1.7 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт нийт 3.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

ХОМК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




ҮЦҚ-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХОМК-уудын нийт хөрөнгө Тайлант улиралд 393.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 5.5 дахин өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 39.6 тэрбум төгрөгөөр, зарлага 31.3 тэрбум төгрөгөөр өсөж 7.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.

ХОМК-ИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ



ХОМК-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ




- Борлуулалтын маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Бусад зардал
- Орлогын татварын зардал



- Хөрөнгө оруулалт менежментийн компаниуд НДШ-д 0.6 тэрбум төгрөг, ХХОАТ-т 0.2 тэрбум төгрөг, ААН-ийн орлогын албан татварт 1.7 тэрбум төгрөгийг тус тус төлж, улсын төсөвт 2.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна.


ХААБ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХААБ-ИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

- ХААБ-уудын нийт хөрөнгө 3.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар буурсан үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.7 тэрбум төгрөгөөр өсөж зарлага 0.1 тэрбум төгрөгөөр буурч 1.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

КАСТОДИАН БАНКНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




КАСТОДИАН БАНКНЫ АШИГТ АЖИЛЛАГАА


- Кастодиан банкны нийт хөрөнгө Тайлант улиралд 2,573.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 51.6 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 0.12 тэрбум төгрөгөөр зарлага 0.01 тэрбум төгрөгөөр өсөж ашиг, алдагдалгүй ажиллажээ.

КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ

- Кастодиан банкны нийт харилцагчдын 96.6 хувийг дотоодын иргэн, 2.9 хувийг дотоодын ААН, 0.3 хувийг гадаадын иргэн, 0.2 хувийг гадаадын ААН тус тус эзэлж байна.




- Кастодиан банканд хадгалагдаж буй хөрөнгийг ангилан үзвэл 98.3 хувийг харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас, 0.4 хувийг мөнгөн хөрөнгө, 1.1 хувийг ХБҮЦ, 0.1 хувийг үүсмэл санхүүгийн хэрэгсэл үл хөдлөх эд хөрөнгө 0.1 хувийг тус тус эзэлж байна.




ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Зах зээлийн үнэлгээний 57.0 хувийг хамгийн өндөр үнэлгээтэй 5 компани, 69.8 хувийг 10 компани бүрдүүлж байна.




ҮЦК-УУДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

- Үнэт цаасны 51 компанийн эргэлтийн харьцаа 1–ээс их нийт компанийн 90.2 хувь буюу 46 ҮЦК, эргэлтийн харьцаа 1–ээс бага түвшинд 9.8 хувь буюу 5 ҮЦК байна.
- Дээрх 51 компанийн өрийн харьцаа бүгд 1–ээс их нийт компанийн 2.0 хувь буюу 1 ҮЦК, эргэлтийн харьцаа 1–ээс бага түвшинд 98.0 хувь буюу 50 ҮЦК байна.



ХОМК-УУДЫН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

- Эргэлтийн хөрөнгийн харьцаа нийт ХОМК-ийн 69.7 хувь буюу 23 нь 1–ээс их, үлдсэн 30.3 хувь буюу 10 нь 1–ээс бага түвшинд байна.
- Харин өрийн харьцаа 1–ээс их нийт компанийн 27.3 хувь буюу 9 ХОМК, 1–ээс бага нийт компанийн 72.7 хувь буюу 24 ХОМК байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан. 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүдийн олонх дэмжиж, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн баталсан. Хууль батлагдсантай холбоотойгоор Хорооны зүгээс шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар зохицуулсан холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулахаар ажиллаж байна.
- 2013 онд Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу болон зохицуулалтын орчныг боловсронгуй болгон өөрчлөн Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 94/А/62 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталлаа.
- Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сард баталсан бөгөөд тус хууль нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор тус хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх хугацаанд хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхэлж байсан зарим компаниуд бүтцийн өөрчлөлт хийж өөр хуулийн этгээдэд үйл ажиллагааг шилжүүлэх эсхүл шинэ хуулийн этгээд байгуулан хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгүүлэх шаардлага тулгарсан бөгөөд тэдгээрийн хувьд Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зарим нөхцөл, шаардлагыг хангах боломжгүй болсон. Үүний хүрээнд Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д Хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 248 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орууллаа.
- Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталсан бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.14-т “Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран батална” гэж заасан. Үүний дагуу Сангийн яам болон тус Хорооны зүгээс дээрх журмыг хамтран боловсруулж, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/105/239 дугаар хамтарсан тушаалаар баталсан.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Санхүүгийн зохицуулах хороо Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг баталсан.
- Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд IPO хийх, компанийн бонд гаргахад тавигддаг нөхцөл, шаардлага, цаг хугацааг бууруулж, IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, мөн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх гэх зэргээр үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зохицуулалтуудыг холбогдох журмуудад тус тус тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулан Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр байршуулж, олон нийтээс санал авч, эцэслэн батлуулахаар ажиллаж байна.
- Мөн ТОП-100 аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд хувьцаа, компанийн бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлага, хугацаа, өртгийг бууруулж, хялбаршуулах зохицуулалтуудыг бүрдүүлэх, холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төслүүдийг хамтран боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:
 1. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон мэргэжлийн оролцогч байгууллагуудтай хамтран аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд гаргахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх, нээлттэй компани болсноор үүсэх давуу тал ач холбогдол болон IPO хийх процесс дараалал, компанийн засаглалын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөхөөр “Хөрөнгийн зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх нэг цэгийн үйлчилгээ”-г 2024 оны 04 дүгээр сарын 23-аас 05 дугаар 14-ний өдрийг хүртэлх мягмар гаригуудад зохион байгууллаа.
 2. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран компаниудын удирдлагуудад зориулсан нээлттэй компани болоход тулгарч буй асуудал болон ажлын хэсгийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулах, санал солилцох “Нээлттэй компани болохын давуу тал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх үр нөлөө” уулзалт, хэлэлцүүлгийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр амжилттай зохион байгуулсан.
- Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцооноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх, компанийн нэр хүндээ өсгөх, урт хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой юм.





ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө

616.6 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **19.0%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Даатгалын нягтрал

***115,405** төгрөг

Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг 2023 оны жилийн эцсээр тооцсон болно.



Хүртээмжтэй байдал

Зуучилсан даатгалын болон давхар даатгалын нийт хураамж

70.0

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

19.8
тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ

тэрбум төгрөг
9.1

Тогтвортой байдал



Давхар даатгалд
төлсөн хураамж

25.7%
тэрбум төгрөг



Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр 339 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,490 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна.



ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

- Гүнзгийрэлт 0.32 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.23 пунктээр, 2020 оны мөн үетэй харьцуулахад 0.25 пунктээр буурсан байна.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.0 хувиар өсөж 616.6 тэрбум төгрөгт хүрсэн бол 2020 оны мөн үетэй харьцуулахад 71.7 хувиар өсжээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.1 хувиар өсөж 529.1 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 85.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар өсөж, 70.1 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 11.4 хувийг эзэлж байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өсөж, 17.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.8 хувийг эзэлж байна.


ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БҮТЭЦ /НИЙТ ХӨРӨНГӨӨР/

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 26.1 тэрбум төгрөг буюу 4.3 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 365.8 тэрбум төгрөг буюу 59.3 хувийг хөрөнгө оруулалт, 47.0 тэрбум төгрөг буюу 7.6 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 177.7 тэрбум төгрөг буюу 28.8 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлж байна.



Даатгалын компаниудыг нийт хөрөнгөд эзэлж буй хувиар нь авч үзвэл 9 хувиас дээш хувийг 3 даатгалын, 6–9 хувийг 4 даатгалын, 3–6 хувийг 5 даатгалын, 3 хувиас доош хувийг 7 даатгалын компани бүрдүүлж байна.


Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь




ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ӨСӨЛТИЙН ТАРХАЛТ

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт өмнөх оны мөн үед 20.0 хувь байсан бол тайлант улиралд 18.2 хувьтай байна. Харин хөрөнгийн өсөлтөөр бүлэглэвэл 30 хувиас дээш өсөлттэй 3, 20–30 хувийн өсөлттэй 7, 10–20 хувийн өсөлттэй 3, 10 хувиас доош өсөлттэй 4, хөрөнгийн хэмжээ буурсан 1 даатгалын компани байна.

2022.II–2023.II / 2023.II–2024.II



- Erdийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Erdийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж



НИЙТ ХУРААМЖ

- Тайлант улиралд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 222.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлж, өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар, 2020 оны мөн үетэй харьцуулахад 134.3 хувиар өсжээ.

Үүнээс: ердийн даатгалын компаниуд 220.4 тэрбум төгрөг буюу 99.2 хувь, урт хугацааны даатгалын компани 1.7 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг бүрдүүлжээ.

- Нийт 57.0 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 4.0 тэрбум төгрөг буюу 7.1 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.

ДАВХАР ДААТГАЛД ТӨЛСӨН ХУРААМЖ


- Erdийн болон урт хугацааны даатгалын нийт хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.3 хувиар, 2020 оны мөн үетэй харьцуулахад 1.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 70.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.0 хувиар, 2020 оны мөн үетэй харьцуулахад 1.5 дахин өсжээ.


Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 69.0 тэрбум төгрөг 98.6 хувийг бүрдүүлжээ.

- Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 дахин өсөж 8.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.



НӨӨЦ САН

- Тайлант улиралд даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.0 хувиар өсөж 290.6 тэрбум төгрөгт хүрсэн.
- Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.4 хувиар өсөж 257.1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 1.8 хувиар өсөж 3.6 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 7.7 хувиар буурч 29.9 тэрбум төгрөг болов.



290.6
Тэрбум төгрөг
2024.И

244.2
Тэрбум төгрөг
2023.И

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ДААТГАЛЫН НЯГТРАЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцоолох боломжгүй. (2023 оны жилийн эцсээр тооцсон тооцооллыг оруулсан болно)



- Даатгалын нягтрал 115,405 төгрөг болж 2022 онтой харьцуулахад 31.4 хувиар, 2019 онтой харьцуулахад 90.1 хувиар тус тус өссөн байна.
- Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 31.5 хувиар өсөж 111,420 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 16.5 хувиар өсөж 926 төгрөгт хүрсэн байна.

Жич: Монгол Улсын 2023.12.31-ний өдрийн байдлаар нийт хүн амын тоог <https://countrymeters.info/en/Mongolia> сайтаас авсан болно.

ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТОО

Нийт 1,006,823 даатгалын гэрээ байгуулагдсан байна. Үүнээс 83.0 хувь буюу 836,135 хувь хүнтэй, 17.0 хувь буюу 170,532 хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ байв.

ХУВЬ ХҮН **836,135**
ХУУЛИЙН
ЭТГЭЭД **170,532**


Хувь хүнтэй байгуулсан гэрээний хүйсийн харьцаа /хувиар/



САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Орон нутагт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын нийт 1,836 төлөөлөгч, 445 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

ДААТГАЛЫН КОМПАНИ, ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН САЛБАР /БАЙРШЛААР/



БАРУУН БҮС

ДААТГАГЧ

46

ЗУУЧЛАГЧ

35

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

5

ХАНГАЙН БҮС

ДААТГАГЧ

56

ЗУУЧЛАГЧ

47

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

14

ТӨВИЙН БҮС

ДААТГАГЧ

76

ЗУУЧЛАГЧ

84

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

22

ЗҮҮН БҮС

ДААТГАГЧ

28

ЗУУЧЛАГЧ

25

ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

7

ТӨЛӨӨЛӨГЧИД

507

597

500

232

САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧ


Улаанбаатар хот

- Улаанбаатар хотод 303 салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулсан ба үүнээс даатгалын компанийн 44, даатгалын зуучлагчийн 217, хохирол үнэлэгчийн 42 салбар байна. Эдгээрийг дүүргээр ангилан үзвэл салбар нэгжийн 92.7 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрчээ.
- Улаанбаатар хотод нийт 654 төлөөлөгч үйл ажиллагаа явуулав.
- Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 14 даатгалын компанийн төлөөлөгчийн газар байгаагаас БНХАУ, БНСУ –д тус тус нэг байна.



	СОНГИНО ХАЙРХАН	ЧИНГЭЛТЭЙ	СҮХБААТАР	БАЯНЗҮРХ
ДААТГАГЧ	4	5	11	5
ЗУУЧЛАГЧ	18	39	48	38
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	10	4	7	9
	ХАН-УУЛ	БАЯНГОЛ	НАЛАЙХ	БАГАНУУР
ДААТГАГЧ	3	5	3	7
ЗУУЧЛАГЧ	36	28	6	4
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	4	7	0	1
	БАГАХАНГАЙ			
ДААТГАГЧ	1			
ЗУУЧЛАГЧ	0			
ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ	0			


БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



- o Ердийн болон урт хугацааны даатгалын нийт 23 хэлбэрээс “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал” –аас бусад нь сайн дурын даатгалын хэлбэр юм.
- o Давхардсан даатгалын бүтээгдэхүүний тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 бүтээгдэхүүнээр өсөж 733 болсон нь 2020 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 116 бүтээгдэхүүнээр өссөн үзүүлэлттэй байна.


Ердийн даатгалын нийт хураамж

2023.II 2024.II




Ердийн даатгалын нөхөн төлбөр

2023.II 2024.II



АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

- Тайлант улиралд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.2 хувиар өсөж 30.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт даатгалын хураамжийн орлогын 13.6 хувийг эзэлж байна.
- Нөхөн төлбөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.9 хувийн өсөлттэй байна. Тайлант улиралд 22.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 38.9 хувийг бүрдүүлжээ.



ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД

Даатгалын зуучлагчдын төвлөрүүлсэн даатгалын болон давхар даатгалын хураамж 69.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өмнөх оны мөн үед 10.1 тэрбум төгрөг байсан бол тайлант улиралд 33.9 хувиар өсөж 13.5 тэрбум төгрөгт хүрэв.



ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД


- Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт 21,288 хохирлыг 38.9 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.2 хувиар өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрэв.



АШИГТ АЖИЛЛАГАА



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ЦЭВЭР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 17.5 дахин өсөж 19.8 тэрбум төгрөгт хүрсэн. Харин 2020 оны мөн үетэй харьцуулахад 69.2 хувиар өссөн байна.
- Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл цэвэр ашгийн хэмжээ буурсан 12, 50 хувь хүртэлх өсөлттэй 2, 50-иас 100 хувь хүртэлх өсөлттэй 2, 100 хувиас дээш өсөлттэй 3 компани байна.



ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хохирол нөхөлтийн харьцаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.
- Тайлант улиралд зардлын харьцаа 7.4 пунктээр буурч 41.5 хувь болжээ.
- Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант улиралд 8.1 пунктээр өсөж 8.8 хувьд хүрлээ.



АШИГТ АЖИЛЛАГААНЫ КОЭФФИЦИЕНТ

- Нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 4.2 пунктээр буурч 0.2 хувьд хүрсэн бол өөрийн хөрөнгийн өгөөж 1.7 пунктээр буурч 0.5 хувьд хүрэв.

- Даатгалын компаниуд нь 5.0 тэрбум төгрөгийг НДШ-д, 1.5 тэрбум төгрөгийг ХХОАТ-т, 2.6 тэрбум төгрөгийг ААН-ийн орлогын албан татварт төлж, нийт 9.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Монгол Улсын даатгалын зах зээлийн тулгамдаж буй асуудлын нэг нь валютын ханшийн эрсдэл юм.
- Даатгалын компаниудын дийлэнх нь гадаад улсад давхар даатгуулдаг бөгөөд сүүлийн гурван жилийн хугацаанд 1 жилд дунджаар 62.0 тэрбум төгрөгийг гадаад улсруу шилжүүлсэн.
- Даатгалын компаниудын гадаад улсад төвлөрүүлсэн давхар даатгалын хураамжийн зардал тайлант улиралд даатгалын нийт хураамжийн 25.7 хувьтай тэнцэж байна.

25.7%

Давхар даатгалын
хураамжийн нийт
хураамжид
эзлэх хувь

- Даатгалын компаниудын нийт хөрөнгийн 59.3 хувийг хөрөнгө оруулалтад хийснээс 72.0 хувь нь хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэртэй байна.
- Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасны хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 34.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон байна.

Хөрөнгө
оруулалтын
дүн


59.3%

Давхар даатгалын хураамж



Жич: 1. Давхар даатгалын хураамжийг өссөн дүнгээр тооцсон.
2. Монголбанкны өдрийн ам.долларын ханш.

Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



*Монголбанкны хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү төгрөгийн

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал шинэчлэн батлагдсан бөгөөд хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Монгол Улсын Их Хуралд өргөн барих чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж байна.
- Даатгалын үйл ажиллагааг зохицуулах дараах журмуудыг шинэчлэх, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллаж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авч байна.
- Жолоочийн даатгалын зохицуулалтыг сайжруулах хүрээнд Хорооны 2018 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг шинэчлэн найруулах;
- Ипотекийн зээлдэгчийн даатгалтай холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, даатгуулагчдад хэрэгцээтэй даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх бодлого, зохицуулалтын шийдвэр гаргах зорилгоор Хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Хилийн бүс дэх Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зохицуулалтыг сайжруулах хүрээнд “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг болно.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох байгууллага AM Best агентлаг болон “Үндэсний давхар даатгал” ХК-тай хамтран Эрсдэлд суурилсан хөрөнгө/RBC/, Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлал/ORSA/ зэрэг сэдвийн хүрээнд даатгалын салбарын 30 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан сургалт, уулзалтыг 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан.
- АХБ-ны “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр”-ийн хүрээнд 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан төслийн зөвлөхүүдтэй уулзах уулзалтад оролцсон.
- Германы хамтын ажиллагааны нийгмэлэг/GIZ/-ээс хэрэгжүүлж буй “Insuring Small and Medium Enterprises (SME) through Blockchain Technology (ISBC)” төслийн хүрээнд Даатгалын мэргэшлийн институт/СII/-ээс гаргасан даатгалын 5 номын чанарын орчуулгыг хийх ажлын багт ажиллаж байна.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Жолоочийн даатгалын зохицуулалтыг сайжруулах хүрээнд 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр жолоочийн даатгалын үйл ажиллагаанд оролцогчдын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан.
- Даатгалын салбарт “СТОУС-17” Даатгалын гэрээ стандартыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор Сангийн яамтай хамтран даатгалын салбарын мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдөр зохион байгууллаа.







БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө

5.8

их наяд төгрөг

Хөрөнгийн өсөлт

45.9%



Санхүүгийн зах зээлийн төлөв

Харилцагч

4.9 сая

Дундаж зээлийн хэмжээ

2.5 сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Зээлийн ББСБ

88.5%

Зөвхөн гадаад валютын
арилжааны ББСБ

10.9%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого
800.9
тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ **70.6**
тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Z индекс
20.7

Чанаргүй зээлийн нийт
зээлд эзлэх хувь

6.2%

Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

2024 оны 2 дугаар улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 549 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа явуулав. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөн





ББСБ-уудын 4.7 хувь нь гадаадын, 95.3 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



ББСБ-УУДЫН ХӨРӨНГӨ

Тайлант улиралд ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 5.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,810.7 тэрбум төгрөгөөр буюу 45.9 хувиар, 2020 оны 2 дугаар улирлаас 3.1 дахин өсжээ.



ББСБ-уудын активын бүтэц /тэрбум төгрөгөөр/


САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,490.5	95.4%	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	706.7	12.3%	
Хөрөнгө оруулалт	77.0	1.3%	
Зээл /цэврээр/	4,558.2	79.2%	
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	21.9	0.4%	
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	1.3	0.0%	
Бусад санхүүгийн хөрөнгө	125.4	2.2%	
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	266.1	4.6%	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,756.6	100.0%	

ББСБ-уудын пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,581.9	44.9%	
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,384.2	41.5%	
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	884.8	15.4%	
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	871.9	15.2%	
Бусад эх үүсвэр	471.1	8.2%	
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	0.4	0.0%	
Бусад санхүүгийн өр төлбөр	155.0	2.7%	
Хоёрдогч өглөг	1.0	0.0%	
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	0.0%	
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	197.7	3.4%	
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,174.7	55.1%	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,682.2	29.2%	
Нэмж төлөгдсөн капитал	82.0	1.4%	
Халаасны хувьцаа	(2.6)	0.0%	
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	13.9	0.2%	
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,329.2	23.1%	
Бусад өмч	70.0	1.2%	
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,756.6	100.0%	

Зах зээлд эзлэх хувь хэмжээг нийт хөрөнгөд эзлэх хувиар нь харвал

- 25 хувийг нэр бүхий 4 ББСБ;
- 50 хувийг нэр бүхий 15 ББСБ;
- 75 хувийг нэр бүхий 72 ББСБ эзэлж байна.




	ББСБ–ын тоо		Нийт хөрөнгө		Нийт зээл		Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь	Харилцагчдын тоо	
	Тоо	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%		Тоо	%
Топ 25 %	4	0.7%	1,463.2	25.4%	1,192.2	26.0%	1.1%	170,305	3.5%
Топ 50 %	15	2.7%	2,920.4	50.7%	2,416.3	52.6%	2.3%	1,143,324	23.4%
Топ 75 %	72	13.1%	4,320.0	75.0%	3,550.2	77.3%	4.0%	4,599,786	94.3%
САЛБАРЫН НИЙТ	549	100.0%	5,756.6	100.0%	4,590.5	100.0%	6.2%	4,875,687	100.0%

Банк бус санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгийн 25, 50 болон 75 хувийг бүрдүүлж буй ББСБ–уудын зээлийн үлдэгдэл салбарын нийт зээлийн үлдэгдлийн 26.0, 52.6, болон 77.3 хувийг тус тус эзэлж байна.

Нийт хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдлийн эзлэх хувь ойролцоо хэдий ч нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь харгалзан 1.1, 2.3 болон 4.0 хувьтай байна. Өөрөөр хэлбэл салбарт эзлэх хувь өндөртэй ББСБ–уудын зээлийн чанар салбарын дундажтай харьцуулахад дунджаас доогуур байна.

	ББСБ–ын тоо	Нийт хөрөнгө		Нийт зээл		Харилцагчдын тоо	
		Хэмжээ /тэрбум төг/	%	Хэмжээ /тэрбум төг/	%	Тоо	%
Дотоодын хөрөнгө оруулалт бүхий	523	4,871.2	84.6%	3,934.2	85.7%	4,786,674	98.2%
Гадаадын хөрөнгө оруулалт бүхий	26	885.4	15.4%	656.3	14.3%	89,013	1.8%


Гадаадын хөрөнгө оруулалтай ББСБ–уудын 50.0 хувь буюу 13 нь Япон, 23.1 хувь нь буюу 6 нь БНСУ, 2 нь АНУ–ын, үлдсэн нь Их Британи, Канад, Малайз, Сичелл, БНХАУ зэрэг бусад улсын хөрөнгө оруулалттай байна. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ–уудын хувьд салбарын нийт хөрөнгийн 15.4 хувийг эзэмшдэг бөгөөд нийт харилцагчдын 1.8 хувьд үйлчилгээ үзүүлдэг болно.



ББСБ–уудын нийт хөрөнгө Монгол Улсын ДНБ–ий 8.2 хувьтай тэнцэхүйц хэмжээнд байна.



Зээлийн хүү: ББСБ-уудын Олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 3.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өссөн байна.



НИЙТ ЗЭЭЛ

Тайлант улиралд салбарын нийт зээлийн хэмжээ 4,590.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.7 хувиар буюу 1,483.0 тэрбум төгрөгөөр, 2020 оны 2 дугаар улирлаас 251.1 хувиар буюу 3.3 их наяд төгрөгөөр өссөн дүнтэй байна.



ХЭВИЙН

90.8%

+1.8%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.0%

-0.3%



ЧАНАРГҮЙ

6.2%

-1.5%

5.5 их наяд төгрөг | Олгосон зээл

Төлөгдсөн зээл | 4.6 их наяд төгрөг

Бөөний болон жижиглэн худалдаа



8.0%

7.5%

Барилга



2.2%

2.3%

Уул, уурхайн олборлолт



0.6%

0.6%

Машин, мотоциклийн засвар үйлчилгээ



1.5%

1.7%

Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээ



1.0%

1.1%

Боловсруулах үйлдвэр



0.5%

0.5%

Хөдөө аж, ахуй



0.5%

0.4%

Бусад



85.7%

85.9%

ИРГЭН



89.1%

93.4%

93.4%

ХУУЛИЙН ЭТГЭЭД



10.9%

6.6%



6.6%

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ



Нийт зээлийн үлдэгдлийн 89.1 хувь нь иргэнд, 10.9 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл эзэлж байна.




ББСБ-ын салбарын зээлийн 27.1 хувийг 1 сар хүртэлх, 24.0 хувийг 6-12 сарын, 15.8 хувийг 2.6-5 жилийн, 14.9 хувийг 1-2.5 жилийн хугацаатай зээл бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 549 ББСБ болон түүний 455 салбар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.






Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн улс орнуудад санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг тооцвол:

21 аймгийн 66.7 хувь буюу 14 аймагт 3 буюу түүнээс дээш тооны ББСБ байна.

1,000 хүн аж ахуй нэгжид ногдох



100,000 хүн амд ногдох



Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 450 ББСБ-ын 32.9 хувь нь Сүхбаатар, 28.2 хувь нь Чингэлтэй, 16.2 хувь нь Баянгол, 11.1 хувь нь Баянзүрх, 9.4 хувь нь Хан-Уул, 2.0 хувь нь Сонгинохайрхан, 0.2 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршилтай байна.

ББСБ-УУДЫН ХҮРТЭЭМЖ, ГАЗАРЗҮЙН БАЙРШЛААР


- Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 51.2 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 10.4 ББСБ ногдож байна.
- Орон нутгийн хэмжээнд уг харьцаанууд нь 27.7, 9.9 байгаа бөгөөд бүс нутгийн хувьд Төвийн бүс 100,000 иргэнд 35.8 ББСБ, зүүн бүс 1,000 аж ахуйн нэгжид 12.5 ББСБ ногдож хүртээмжээр тэргүүлж байна.
- Улаанбаатар хотын хувьд 100,000 иргэнд 76.5 ББСБ, 1,000 аж ахуйн нэгжид 10.6 ББСБ ногдож байгаа нь орон нутгаас хүртээмж сайтай байна

Улсын хэмжээнд
100,000 хүнд

51
ББСБ

1,000 аж
ахуйн нэгжид


10
ББСБ




ДУНДАЖ ЗЭЭЛ

- Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 2.5 сая төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 1.9 сая төгрөг, Улаанбаатар хотын хувьд 2.5 сая төгрөг байна.
- Уг үзүүлэлт өмнөх оны мөн үед улсын хэмжээнд 2.4 сая төгрөг байсан ба тайлант улирлын хувьд ББСБ-аас зээл авсан нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 4.7 хувиар өсчээ.
- Давхардсан тоогоор нийт зээлдэгчдийн тоо 1.9 сая байгаа нь хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 100 хүн тутмын 95.1 нь ББСБ-аас зээлтэй байна гэсэн үг юм.


ББСБ-ын харилцагчид



ББСБ-ын зээлдэгчид /насны бүлгээр/



ББСБ-ын зээлдэгчид /боловсролын түвшингээр/



ББСБ-ын ажилчид

Эрэгтэй
40.9%



Эмэгтэй
59.1%



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ



ББСБ-ЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО

Бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого: ББСБ-уудын нийт орлого 800.9 тэрбум төгрөгт хүрэв.

Үүнээс 98.0 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу хүүгийн болон хүүгийн бус орлого бүрдүүлж байгаагаас 89.0 хувь буюу 712.9 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, 9.0 хувь нь буюу 72.1 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна.




ХҮҮГИЙН БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА

- Хүүгийн бус орлогын 77.7 хувийг санхүүгийн үйлчилгээний орлого, 8.0 хувийг арилжааны орлого, 6.6 хувийг гадаад валютын ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 7.7 хувийг бусад хүүгийн бус орлого бүрдүүлж байна.


БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

- Зардал 475.8 тэрбум төгрөгт хүрсэн. Уг зардалын 77.5 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал буюу хүүгийн болон хүүгийн бус зардал эзэлж байгаа бол 42.3 хувь буюу 201.3 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал, 35.2 хувь нь буюу 167.7 тэрбум төгрөгийг хүүгийн зардал бүрдүүлж байна.





Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлтэй холбоотой гарах зардал буюу болзошгүй эрсдэлийн зардал 46.2 тэрбум төгрөг ба үүний 93.8 хувийг зээлийн эрсдэлийн зардал, 2.6 хувийг өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, 1.1 хувийг факторингийн тооцооны авлагын эрсдэлийн сангийн зардал, 0.6 хувийг авлагын эрсдэлийн сангийн зардал, 0.4 хувийг банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, 1.5 хувийг бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал тус тус эзэлж байна.

- Салбарын хэмжээнд нийт 21.9 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлага бүртгэлтэй байна.

Факторингийн үйлчилгээний цэвэр авлага
/тэрбум төгрөг/

- 76 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байгаа ба эх үүсвэр 884.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 96.9 хувиар өсжээ.

Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр
/тэрбум төгрөг/Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлого
/сая төгрөг/


- Уг үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 51 ББСБ-аас 14 ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээнээс 3.0 тэрбум төгрөгийн орлого олжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 753.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

ХУДАЛДСАН, ХУДАЛДАН АВСАН ВАЛЮТЫН МЭДЭЭ

ББСБ-ууд нийт 1,613.4 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 1,741.5 тэрбум төгрөгийн валютыг худалдсан байна. Худалдаж авсан валютын 48.8 хувийг, худалдсан валютын 44.2 хувийг АНУ-ын доллар бүрдүүлж байна.


ВАЛЮТЫН НЭР	Худалдаж авсан	Худалдсан
	Дүн /тэрбум төгрөг/	Дүн /тэрбум төгрөг/
АНУ-ЫН ДОЛЛАР	787.2	769.1
БНХАУ-ЫН ЮАНЬ	616.1	610.2
ОХУ-ЫН РУБЛЬ	99.7	103.4
ЕВРО	63.1	66.7
БНСУ-ЫН ВОН	27.4	173.1
ЯПОНЫ ИЕН	14.1	12.7
БУСАД	5.9	6.2


АШИГТ АЖИЛЛАГАА



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ТАРХАЛТ

ББСБ-уудын нийт хөрөнгийн өгөөж 11.5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 3 пунктээр, өөрийн хөрөнгийн өгөөж 6.7 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1.4 пунктээр тус тус өссөн байна. Нийт ББСБ-ын 24.8 хувь нь 1 хувиас доош өөрийн хөрөнгийн өгөөжтэй, 28.1 хувь нь 1 хувиас 5 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй, 23.1 хувь нь 5 хувиас 10 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй, 24.0 хувь 10 хувиас дээш өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллалаа. Нийт хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 25.5, 31.1, 27.0, 16.4 хувийн өгөөжтэй ажиллалаа.






НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦАА /ХӨРӨНГИЙН АНГИЛЛААР/

ББСБ-уудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 1.0 тэрбум төгрөгөөс доош хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 5.9 хувиас бага, 1.0–2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 2.9 хувиас бага, 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 3.3 хувиас бага нийт хөрөнгийн өгөөжтэй байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд холбогдох утгууд нь харгалзан 7.7, 3.0 болон 3.9 хувьтай байна.


ЗАРДАЛ, ОРЛОГЫН ХАРЬЦАА

ББСБ-ууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог зардал, орлогын харьцаа 59.4 хувь гарсан буюу өмнөх оны мөн үеэс 4.2 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100.0 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 59.4 төгрөгийн зардал гаргаж байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- o AFI-с санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох зөвлөмж зааврын дагуу ББСБ-уудын дараах 4 үзүүлэлтийг тооцож байна. Үүнд:




ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХАРЬЦАА

Уг харьцаа 107.2 хувь гарч байгуулвал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг мөн хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.


Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.8 нэгжээр буурсан үзүүлэлт юм.

107.2%




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

Чанаргүй зээлийн хэмжээ 282.8 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 6.2 хувь болжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.5 нэгжээр буурсан байна.




ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА

- Уг харьцаа 12.3 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр буурсан.




Z ИНДЕКС

Z индекс нь ББСБ-ын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. Банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оны мөн үеэс 1.3 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.



Нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлт



СТАНДАРТ ХАЗАЙЛТ

Нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлтыг сүүлийн 4 улирлын өгөөж дээр суурилан тооцдог. Стандарт хазайлт гэдэг нь өгөгдлүүд дундаж хэмжээнээс хир өөрчлөлттэй байгааг тодорхойлдог статистик үзүүлэлт юм. Стандарт хазайлтын утга их байх нь өгөөж хэлбэлзэл ихтэйг илэрхийлдэг бол бага утга нь өгөөж хэлбэлзэл багатай, тогтвортой байгааг илэрхийлнэ. Тайлант улиралд уг утга нь 2.99 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.09 пунктээр буурсан байна.

ФИНТЕК

	Нийт зээл		Зээлдэгчийн тоо		1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян. төгрөг/
	Хэмжээ /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	
Финтек	991.5	21.6%	1,675,055	89.8%	591.9
Уламжлалт	3,598.9	78.4%	190,911	10.2%	18,851.4
НИЙТ	4,590.5	100.0%	1,865,966	100.0%	2,460.1

56 ББСБ

7

Зөвхөн технологид суурилсан

49

Технологи + Уламжлалт

- Салбарын нийт харилцагчдын 95.2 хувь, нийт зээлдэгчдийн 89.8 хувь нь эдгээр 56 ББСБ-аас үйлчилгээ хүртжээ.



92.2% Хэвийн

2.7% Хугацаа хэтэрсэн зээл

5.1% Чанаргүй




95.2%

Финтек харилцагчид


Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 92.2 хувь нь хэвийн, 2.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 5.1 хувь нь чанаргүй зээлийн ангилалд байна.

Зөвхөн технологид суурилсан



Зөвхөн технологид суурилсан зээл олгодог 7 ББСБ-уудын хувьд салбарын зээлдэгчдийн 44.3 хувийг эзлэж байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 6.2 хувийг эзлэж байгаа ч олгосон зээлийн 23.9 хувийг, төлөгдсөн зээлийн 26.6 хувийг эзлэж байгаа нь эдгээр ББСБ-уудын зээлийн эргэлт сайтай байгаа нь харагдаж байна.

НОГООН ЗЭЭЛ



Ногоон зээлийн үлдэгдэл: 12 нэр төрлийн ногоон зээлийг 4,577 зээлдэгчид олгосон нь нийт зээлийн үлдэгдлийн 2.5 хувь буюу 115.2 тэрбум төгрөг байна.

	Ногоон зээл (хувиар)	Зээлдэгчдийн Тоо	Нийт зээлийн үлдэгдэл /сая төгрөг/
Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	0.1%	4	101.5
Эрчим хүчний үр ашиг	0.2%	67	240.1
Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	8.2%	721	9,401.0
Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	11.6%	156	13,395.0
Тогтвортой ус, хог хаягдал	0.0%	–	–
Тогтвортой хөдөө аж, ахуй	5.0%	1	5,810.6
Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	0.9%	5	998.0
Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	65.2%	3,620	75,137.4
Мэдээлэл, харилцаа холбоо, технологи	0.0%	–	–
Эрүүл мэнд	0.2%	1	273.1
Боловсрол, Соёл	0.0%	1	4.0
Хүртээмжтэй дэд бүтэц	8.6%	2	9,877.0



ХЭВИЙН
89.6%




ХУГАЦАА ХЭТЭРСЭН
8.2%



ЧАНАРГҮЙ
2.2%

НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ ТЭЭВЭР



- Цахилгаан тээврийн хэрэгсэл
- Хосолсон хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл
- Хэмнэлттэй тээврийн хэрэгсэл
- Дугуй, скүүтэр
- Бусад

ТАЙЛАНТ УЛИРАЛД ОЛГОСОН ЗЭЭЛ

Төрөл	Ногоон зээлийг (хувиар)	Зээлдэгчдийн тоо	Олгосон зээлийн дүн (сая төгрөг)
Эрчим хүчний хангамж, дэд бүтэц	0.4%	52	122.4
Эрчим хүчний үр ашиг	0.4%	24	137.4
Тогтвортой хот төлөвлөлт ба барилга	10.4%	238	3,399.7
Бохирдлыг бууруулах ба сэргийлэх	11.3%	69	3,710.7
Тогтвортой газар ашиглалт ба биологийн олон янз байдал	0.0%	1	10.0
Нүүрс хүчлийн хийн ялгарал багатай тээвэр	73.9%	1,110	24,291.0
Эрүүл мэнд	0.1%	1	30.0
Боловсрол, Соёл	0.0%	1	4.0
Хүртээмжтэй дэд бүтэц	3.5%	1	1,151.0

Нэр бүхий 26 ББСБ 9 төрлийн ногоон бүтээгдэхүүнд 32.9 тэрбум төгрөгийн зээл олгожээ.



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/226/528 тоот хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд ББСБ-ууд энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Шинэчилсэн журамд СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС-13 Бодит үнэ цэнийн хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар тусгасан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

- 2024 оны II улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 94.2 хувь буюу 485 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 97.0 хувь буюу 470 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.
- 2024 оны II улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 486 ББСБ-ын 95.5 хувь буюу 464 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2024 оны II улирлын байдлаар нийт 516 ББСБ-аас 1,293.0 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 98.5% буюу 506 ББСБ 1,273.9 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 106 ББСБ, 5,457 удаагийн тохиолдлоор, 657.7 сая төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 6 ББСБ, 193 удаагийн тохиолдлоор, 2,474.0 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын салбарын бодлого зохицуулалтын чиглэлээр дараах олон улсын байгууллага, холбоодтой хамтран ажиллаж байна.

- ТоС Холбоо, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, болон олон улсын түнш (GCF/TDBM, CTIF, UNDP, ESCAP, FC4S, IFC) байгууллагуудтай хамтран зохион байгуулсан “Тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагналын семинар, хэлэлцүүлэг” арга хэмжээнд 2024 оны 4 дүгээр сарын 30-нд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл оролцов.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны төсөл /Knowledge and Support Technical Assistance on Developing Fintech Legal and Regulatory Frameworks for Mongolia/” 2023 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжиж байна. Төслийн зөвлөх компани болон АХБ-ны төлөөлөл дээрх зорилгын хүрээнд боловсруулсан эхний шатны зөвлөмжийн төслийг хэлэлцүүлэх уулзалтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж Санхүүгийн зохицуулах хороо ББСБ-ын финтекийн орчны талаар санал солилцож, эрх зүйн орчны талаар танилцуулав.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө

327.8 тэрбум төгрөг

Хөрөнгийн өсөлт **10.8%**



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нийт салбар **61**

Нийт гишүүдийн

43.7%

дээд боловсролтой



Хүртээмжтэй байдал

Нийт хадгаламж

242.3

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Цэвэр ашиг

5.8

тэрбум төгрөг

Улсад татан
төвлөрүүлсэн
татвар, НДШ

2.3

тэрбум төгрөг

Тогтвортой байдал



Нийт зээлд эзлэх чанаргүй
зээлийн хувь

2.8%

Мөнгөн хөрөнгийн нийт
хөрөнгөд эзлэх хувь

20.1%


Бодлого зохицуулалт



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

ХЗХ–ДЫН ТОО БА ГИШҮҮД

- Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–ны тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11–ээр буюу 5.7 хувиар буурч 181 боллоо.
- ХЗХ–дын гишүүний тоо 2023 оны 2 дугаар улиралд 71,184 байсан бол тайлант улиралд 4.2 хувиар өсөж 74,186 болжээ.
- Харин 2020 оны мөн үетэй харьцуулбал ХЗХ–ны тоо 29.3 хувиар буурч, гишүүний тоо 2.7 хувиар өссөн.



АЖИЛЛАГСАД

622

Өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар буурсан ба 73.2 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

НИЙТ ГИШҮҮДИЙН


29,936

ЗЭЭЛДЭГЧ

43,466

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

■ Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/ ○ Нийт хөрөнгийн өсөлт /хувь/



НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ

- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар, 2020 оны мөн үеэс 39.8 хувиар тус тус өсөж 327.8 тэрбум төгрөгт хүрлээ.

НИЙТ ЗЭЭЛ

243.4

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ХАДГАЛАМЖ

226.1

ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Салбарын нийт хөрөнгийн

- 89.0 хувийг 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 35 ХЗХ;
- 5.1 хувийг 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл хөрөнгөтэй 23 ХЗХ;
- 5.9 хувийг 500 сая төгрөгөөс доош хөрөнгөтэй 123 ХЗХ эзэлж байна.



Тайлангийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


Нийт хөрөнгийн дүн	327.8	100.0%
Санхүүгийн хөрөнгө	318.6	97.2%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	65.8	20.1%
Зээл /цэврээр/	246.6	75.2%
Бусад санхүүгийн хөрөнгө	6.1	1.9%
Санхүүгийн бус хөрөнгө	9.2	2.8%
Татварын авлага	0.4	0.1%
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	0.0	0.0%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3.2	1.0%
Бараа материал	0.3	0.1%
Өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	0.7	0.2%
Бусад санхүүгийн бус хөрөнгө	0.1	0.0%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /цэврээр/	0.0	0.0%
Үндсэн хөрөнгө /цэврээр/	4.4	1.4%
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.1	0.0%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	327.8	100.0%
Санхүүгийн өр төлбөр	251.6	76.8%
Хадгаламж	242.3	74.0%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	7.7	2.3%
Бусад санхүүгийн өр төлбөр	1.6	0.5%
Санхүүгийн бус өр төлбөр	3.0	0.9%
Өөрийн хөрөнгө	73.2	22.3%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	28.6	8.7%
Өмчийн бусад хэсэг	0.4	0.1%
Хоршоологчдын өмч	44.2	13.5%

Тайлбар:

*Сангийн сайдын 2024 оны А/49 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу боловсруулсан болно.

- Нийт хөрөнгийн 97.2 хувь нь санхүүгийн хөрөнгө, үлдсэн 2.8 хувь нь санхүүгийн бус хөрөнгө байна.
- Санхүүгийн хөрөнгийн бүрдлийг нийт хөрөнгөд эзлэх хувиар задалбал 20.1 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 75.2 хувийг цэвэр зээл, 1.9 бусад санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байна.
- Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 76.8 хувийг санхүүгийн өр төлбөр, 22.3 хувийг өөрийн хөрөнгө, 0.9 хувийг санхүүгийн бус өр төлбөр бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ



БАРУУН БҮС

40 ХЗХ

8 САЛБАР

ХАНГАЙН БҮС

17 ХЗХ

18 САЛБАР

ТӨВИЙН БҮС

21 ХЗХ

20 САЛБАР

ЗҮҮН БҮС

11 ХЗХ


11 САЛБАР

УЛААНБААТАР

92 ХЗХ

4 САЛБАР

- 92 ХЗХ нь Улаанбаатар хотод, 89 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын 44.9 хувь нь баруун бүсэд, 23.6 хувь нь төвийн бүсэд, 19.1 хувь нь хангайн бүсэд, 12.4 хувь нь зүүн бүсэд байршжээ.
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 92 ХЗХ-ны 96.7 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 3.3 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байршиж байна.



“Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-ийн улс орнуудын санхүүгийн хүртээмжийг үнэлэх үндсэн индикаторуудыг¹ ашиглан салбарын хүртээмжтэй байдлыг хөдөлмөрийн насны буюу 18–64 насны 10,000 хүнд ногдох, 1,000 аж ахуйн нэгж (ААН)-д ногдох ХЗХ-дын тоогоор тооцоолоход дараах байдалтай байна.




- 1,000 ААН-д ногдох ХЗХ-ны тоогоор Налайх дүүрэг 2.8, Чингэлтэй дүүрэг 2.5 үзүүлэлттэйгээр тус тус тэргүүлж байгаа бол Баянгол дүүрэг 0.7 гэсэн үзүүлэлттэйгээр хамгийн доогуур жагсаж байна.
- 10,000 хүнд ногдох ХЗХ-ны тоогоор Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд тус тус 2.9, 2.2 гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байна.

¹ <https://www.afi-global.org/sites/default/files/publications/fidwg-core-set-measuring-fi.pdf>

10 000 хүнд ногдох ХЗХ–ны тоо



1 000 ААН–д ногдох ХЗХ–ны тоо



Хүртээмжийн үзүүлэлтийг 4 бүсээр ангилахад баруун бүс 10,000 хүнд ногдох, 1,000 ААН–д ногдох ХЗХ–дын тоогоор бусад бүсээс илүү үзүүлэлттэй байна.

Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл



ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 66 хүн тутмын нэг нь ХЗХ–нд гишүүнчлэлтэй, зээлийн үйлчилгээ хүртжээ.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 63 хүн тутмын нэг бол Улаанбаатар хотын хэмжээнд 69 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ–ноос зээл авсан гишүүн дунджаар 8.1 сая төгрөгийн зээлтэй.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 13.4 сая төгрөг, орон нутагт 3.6 сая төгрөг байна.




ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- Улсын хэмжээнд 18–64 насны 45 хүн тутмын нэг нь ХЗХ–нд хадгаламжаа байршуулжээ.
- Дээрх үзүүлэлт орон нутагт 50 хүнд нэг, Улаанбаатар хотын хэмжээнд 41 хүнд нэг тохиож байна.
- Улсын хэмжээнд ХЗХ–нд хадгаламж эзэмшигч гишүүн дунджаар 5.2 сая төгрөгийн хадгаламжтай.
- Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 7.6 сая төгрөг, орон нутагт 2.4 сая төгрөг байна.

Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ




ХЗХ-НЫ ГИШҮҮДИЙН ХҮРТЭЭМЖ



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХЗХ–ДЫН ЗЭЭЛ

- Тайлант улиралд ХЗХ–дын зээлийн үлдэгдэл дүн 243.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 22.9 тэрбум төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн үзүүлэлт юм.
- 2020 оны мөн үетэй харьцуулбал нийт зээл 78.3 тэрбум төгрөгөөр буюу 47.4 хувиар нэмэгджээ.
- Цэвэр зээлийн хэмжээ 246.6 тэрбум төгрөгт хүрсэн бол, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 4.9 тэрбум төгрөг болсон байна.



ХЭВИЙН

94.2%



ХУГАЦАА ХЭТЭРСЭН

3.0%



ЧАНАРГҮЙ

2.8%

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЧАНАР

- Хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өсөж 229.3 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт зээлийн 94.2 хувийг хэвийн зээл эзэлж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар буурч 7.2 тэрбум төгрөгт боллоо.
- Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буурч 6.8 тэрбум төгрөгт хүрэв.
- 2020 оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн дүн 0.3 тэрбум төгрөгөөр буюу 4.1 хувиар буурчээ.

ХЗХ–ДЫН ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

- Нийт зээлийн 38.0 хувийг хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд, 6.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар, 6.1 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаанд зориулж олгосон байна.
- Нийт эргэн төлөгдсөн зээлийн 29.7 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, 7.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар, 2.0 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт олгосон зээлээс төлөгджээ.
- Нийт хаагдсан зээлийн 44.1 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, 7.3 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 6.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар олгосон зээлээс хаагджээ.

ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ

ОЛГОСОН ЗЭЭЛ

ХААГДСАН ЗЭЭЛ

Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа



29.7% 38.0% 44.1%

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ



7.1% 6.6% 6.9%

ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур



2.0% 1.9% 2.3%

Санхүүгийн, даатгалын үйл ажиллагаа



0.9% 6.1% 7.3%

Барилга



1.8% 1.4% 1.5%

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа



1.8% 0.9% 0.1%

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ



1.2% 0.8% 0.6%

Боловсруулах үйлдвэр



0.7% 0.4% 0.2%

Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа




0.8% 0.5% 0.4%

Бусад



54.0% 43.4% 36.6%

■ Нийт хадгаламж /тэрбум төгрөг/ ○ Хадгаламжийн өсөлт /хувь/



ХЗХ-ДЫН ХАДГАЛАМЖ

- Тайлант улирлын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өсөж 226.1 тэрбум төгрөг боллоо.
- 2020 оны мөн үетэй харьцуулбал 62.7 тэрбум төгрөгөөр буюу 38.4 хувиар нэмэгджээ.

НИЙТ ХАДГАЛАМЖ

- 97.8 хувийг хугацаатай хадгаламж, 2.2 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.



97.8%

ХУГАЦААТАЙ



2.2%

ХУГАЦААГҮЙ



180 ХЗХ



1 ХЗХ

- ХЗХ-дын 99.4 хувь буюу 180 ХЗХ нь 226.1 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн.
- Үлдсэн 0.6 хувь буюу 1 ХЗХ хадгаламж татаагүй байна.

НИЙТ ХАДГАЛАМЖИД ЭЗЛЭХ ХУВЬ

- 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 22 ХЗХ 196.1 тэрбум төгрөгийн хадгаламж татан төвлөрүүлсэн нь зах зээлийн нийт хадгаламжийн 86.7 хувийг;
- 10 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 143 ХЗХ 29.9 тэрбум төгрөгийн хадгаламж татан төвлөрүүлсэн нь зах зээлийн нийт хадгаламжийн 13.26 хувийг;
- 10 саяас доош төгрөгийн хадгаламжтай 15 ХЗХ 0.1 тэрбум төгрөгийн хадгаламж татан төвлөрүүлсэн нь зах зээлийн нийт хадгаламжийн 0.04 хувийг тус тус бүрдүүлж байна.
- Огт хадгаламж татаагүй 1 ХЗХ байна.




1.3%

Хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж сарын хүү



2.3%

Зээлийн жигнэсэн дундаж сарын хүү



ОРЛОГО

Тайлант улиралд ХЗХ–дын хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.6 хувиар өсөж 33.7 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд;

- Зээлийн хүүгийн орлого 85.7 хувь буюу 28.9 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого 11.7 хувь буюу 3.9 тэрбум төгрөг;
- Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого 2.7 хувь буюу 0.9 тэрбум төгрөг;
- Зээлийн хүүгийн орлогын буцаалт 0.1 хувь буюу 0.04 тэрбум төгрөг.



ЗАРДАЛ

Тайлант улиралд ХЗХ–дын хүүгийн зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.4 хувиар өсөж 19.3 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд:



- Хадгаламжийн хүүгийн зардал 98.5 хувь буюу 19.0 тэрбум төгрөг;
- Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал 1.5 хувь буюу 0.3 тэрбум төгрөг;
- Санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал 0.1 хувь буюу 0.02 тэрбум төгрөг;
- Хүүгийн зардлын буцаалт 0.1 хувь буюу 0.02 тэрбум төгрөг байна.



АШИГТ АЖИЛЛАГАА

ХЗХ–ДЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

- Тайлант улиралд ХЗХ–ны салбар 36.0 тэрбум төгрөгийн орлого олж, 30.2 тэрбум төгрөг зарцуулж, 5.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.
- Цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 7.1 пунктээр өсөж 16.2 хувьд хүрчээ.



НИЙТ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ


- Татварын дараах цэвэр ашгаар тооцоолоход ХЗХ–дын өөрийн хөрөнгийн өгөөж нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 пунктээр өсөж 8.0 хувьд хүрлээ.
- Нийт хөрөнгийн өгөөж нь 1.8 хувь болов.




- ХЗХ–д нийгмийн даатгалын шимтгэлд 1.2 тэрбум төгрөг, ХХОАТ–г 0.4 тэрбум төгрөг, ААН–ийн орлогын албан татварт 0.7 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

ГОЛЛОХ ХАРЬЦААНУУД

- Хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0.9 пунктээр өсөж 13.9 хувьд хүрлээ.
- Цэвэр орлогыг нийт орлогод харьцуулан тооцдог цэвэр ахиуц ашгийн харьцаа нь өмнөх оны мөн үеэс 7.1 пунктээр өсөж 16.2 хувь болжээ.




■ Үйл ажиллагааны зардал ■ Нийт орлого ○ Үйл ажиллагааны зардал / Нийт орлого



ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА

- ХЗХ-дын 100.0 төгрөгийн орлого тутамд 25.8 төгрөгийн үйл ажиллагааны зардал ногдож байна.




ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХЗХ нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг дараах үндсэн 4 үзүүлэлт /PEARLS аргачлал/-ийн дагуу тооцож, мөрдлөг болгон ажилладаг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт;
2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт.

■ Чанаргүй зээл /тэрбум төгрөг/ ○ Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь




ХЗХ-ДЫН ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

- Чанаргүй зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 0.5 тэрбум төгрөгөөр буурч 6.8 тэрбум төгрөг боллоо.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурч 2.8 хувьд хүрсэн. ХЗХ-дын мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр энэхүү үзүүлэлт 5 хувиас бага байхыг шаарддаг.

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ


- Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.6 пунктээр өсөж 33.0 хувь болжээ.
- Эргэлзээтэй зээлийн хувьд өмнөх оны мөн үеэс 14.1 пунктээр буурч 20.3 хувьд хүрсэн бол муу зээл 7.5 пунктээр өсөж 46.7 хувьд хүрлээ.

■ Хэвийн бус зээл ■ Эргэлзээтэй зээл ■ Муу зээл




ХЗХ-ДЫН ХӨРВӨХ ЧАДВАР:

- ХЗХ-дын нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа 20.1 хувьтай байна.
- Богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт 74.2 хувь боллоо.



- Зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь
- Зээлийн эрсдэлийн сангийн нийт хөрөнгөд эзлэх хувь



ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН

- ХЗХ-дын зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 2.0 хувь, харин нийт хөрөнгөд эзлэх хувь 1.5 хувь байна.

Харьцаа	Зохистой хувь	Жилийн эцэс
Бусдаас авсан зээл/Нийт зээл	<20%	3.2%
Нийт хадгаламж/Нийт хөрөнгө	20%–80%	69.0%
Цэвэр зээл/Нийт хөрөнгө	60%–85%	75.2%
Хоршоологчдын өмч/Нийт хөрөнгө	>5%	13.5%
Нөөцийн сан/Хоршоологчдын өмч	>3%	32.7%
Хадгаламж хамгааллын сан/Хоршоологчдын өмч	>5%	7.3%
Тогтворжилтын сан/Хоршоологчдын өмч	>5%	7.1%
Үйл ажиллагааны зардал/Нийт хөрөнгө	<15%	2.8%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Сангийн яамтай хамтран боловсруулж, Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. Журам танилцуулах сургалтыг Сангийн яамтай хамтран Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны төлөөлөл болон хадгаламж, зээлийн хоршоодын гүйцэтгэх захирал, нягтлан бодогчид, аудитын байгууллага, санхүүгийн программ хангамжийн компанийн төлөөлөл 145 оролцогчийг хамруулан 2024 оны 04 дүгээр сарын 11, 18 болон 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 286 дугаар тогтоолоор “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6880 дугаарт бүртгүүлсэн.
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 254 тоот тушаалаар баталсан.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Азийн Хөгжлийн Банктай хамтран ТА-6883 REG: “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азийн жендерийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төслийг хэрэгжүүлж, Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн эмэгтэй бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ногоон санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгааг хийж гүйцэтгэсэн. Суурь судалгааны үр дүнд үндэслэн Хадгаламж, зээлийн хоршоодод ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломжийн талаар 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр нийт хадгаламж зээлийн хоршоод, бодлого тодорхойлогч болон дэмжигч байгууллагын төлөөлөгчийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- Азийн Хөгжлийн Банктай хамтран ТА-9654MON “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хадгаламж, зээлийн хоршооны зах зээлд 2019-2023 онд амжилттай хэрэгжүүлж хэрэгжүүлж дуусгалаа.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 384 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2.1.16-д заасны дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн хорооны гишүүдэд 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан “Хадгаламж, зээлийн хоршооны зээлийн үйл ажиллагаа” сургалтад “Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тойм”, “Тогтвортой санхүүгийн суурь ойлголт, олон улсын чиг хандлага” сэдвээр мэдээлэл өгч, 23 оролцогчид гэрчилгээ олгосон.
- Монголын хуульчдын холбооноос 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан “Хуульчийн Про Боно өдөр 2024”-т оролцож иргэдэд хадгаламж, зээлийн хоршооны хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгсөн.
- Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдсан “Номын баяр”-т 2024 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд оролцож иргэдэд хадгаламж, зээлийн хоршооны салбарын талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн.
- Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хуралдуулж өнөөгийн нөхцөл байдал, хяналт шалгалт, зохицуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг сэдвээр мэдээлэл өгч, хэлэлцүүлсэн.



МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

Нийт хөрөнгө

771.2
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Улаанбаатар

211

Хөдөө орон нутаг

136



Хүртээмжтэй байдал

Тээврийн хэрэгсэл

43.6%



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

97.7 тэрбум төгрөг

Тайлант үеийн ашиг

40.0 тэрбум төгрөг


Тогтвортой байдал



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч /МЗҮАЭ/ этгээдийн тоон мэдээлэл


2024 оны 2 дугаар улирлын байдлаар 347 этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 229 хуулийн этгээд, 118 нь иргэнээр үйл ажиллагаа явуулж байна. 229 хуулийн этгээдийн 65 нь Санхүүгийн зохицуулах хороонд, 164 нь аймаг, нийслэлийн засаг даргад бүртгүүлсэн байна.



Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хөрөнгө, зээл

Нийт 771.2 тэрбум төгрөгийн хөрөнгө, 510.1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй бөгөөд нийт зээлийн 3.8 хувь буюу 29.2 тэрбум төгрөг хугацаа хэтэрсэн зээл байна.

Нийт хөрөнгө, нийт зээл /тэрбум төгрөг/



МЗҮАЭ–дийн активын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	700.4	90.8%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	46.9	6.1%
НИЙТ ЗЭЭЛ	510.1	66.2%
ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ	23.9	3.1%
БУСАД ХӨРӨНГӨ	119.5	15.5%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	70.8	9.2%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	771.2	100.0%


Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийт хөрөнгийн 6.1 хувийг мөнгөн хөрөнгө, 66.2 хувийг нийт зээл, 3.1 хувийг өмчлөх бусад хөрөнгө, 15.5 хувийг бусад хөрөнгө нийт 90.8 хувь буюу 700.4 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө үлдсэн 9.2 хувь буюу 70.8 тэрбум төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна.

МЗҮАЭ–дийн пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ӨР ТӨЛБӨР	974.1	48.5%
ЗЭЭЛ	125.4	16.3%
ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	76.3	9.9%
БУСАД ӨР ТӨЛБӨР	172.3	22.3%
ЭЗДИЙН ӨМЧ	397.1	51.5%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	108.4	14.1%
ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ	288.7	37.4%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	771.2	100.0%

Өр төлбөрийн хувьд 125.4 тэрбум төгрөгийг зээл, 76.3 тэрбум төгрөгийг гаргасан өрийн бичиг, 172.3 тэрбум төгрөгийг бусад өр төлбөр эзлэх бөгөөд нийт хөрөнгийн 48.5 хувийг эзэлж байна. Үлдсэн 397.1 тэрбум төгрөг буюу 51.5 хувийг эздийн өмч бүрдүүлжээ.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




- Улсын хэмжээнд 347 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна. Байршлыг зураглалаар харуулбал дийлэнх буюу 60.8 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.
- Бүсээр нь авч үзвэл баруун бүст 3 иргэн, 3 хуулийн этгээд, хангайн бүст 76 иргэн, 12 хуулийн этгээд, төвийн бүст 10 иргэн, 25 хуулийн этгээд, зүүн бүст 3 иргэн, 4 хуулийн этгээд бүртүүлэн үйл ажиллагаа явуулж байна.



- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 211 мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн 28.9 хувь нь Баянзүрх, 24.2 хувь нь Сүхбаатар, 17.1 хувь нь Баянгол, 13.7 хувь нь Хан-Уул, 11.8 хувь нь Чингэлтэй, 2.8 хувь нь Сонгинохайрхан, 0.9 хувь нь Налайх, 0.6 хувь нь Багануур дүүрэгт тус тус байршиж байна.
- Үйл ажиллагаа явуулж буй мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн 26 нь иргэн, 185 нь хуулийн этгээд байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ОЛГОСОН ЗЭЭЛИЙН БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ТӨРЛӨӨР



Нийт олгосон зээлийг төрлөөр нь авч үзвэл 43.6 хувь нь тээврийн хэрэгсэл, 28.0 хувь нь үнэт эдлэл, 3.3 хувь нь орлого барьцаалсан зээл, 2.7 хувь нь цахилгаан хэрэгсэл, 0.9 хувь нь тавилга эд хогшил, 0.9 хувь нь эзэмших эрх, 0.3 хувь нь тоног төхөөрөмж, 20.2 хувь нь бусад төрлийн зээлд тус тус олгосон байна.

АШИГТ АЖИЛЛАГАА




ЗАРДЛЫН БҮТЭЦ

Нийт зардлын 86.7 хувь буюу 50.0 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардал үлдсэн 13.3 хувь буюу 7.7 тэрбум төгрөгийг бусад зардал бүрдүүлж байна.

ОРЛОГЫН БҮТЭЦ

Нийт орлогын 83.0 хувийн зээлийн хүүгийн орлого, 0.4 хувийг харилцах, хадгаламжийн хүүгийн орлого, 0.2 хувийг бусад хүүгийн орлого үлдсэн 16.4 хувийг бусад орлого бүрдүүлж байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталж, 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус салбарт мөрдөгдөх журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, шинэчлэн дараах журмуудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв.

- “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 81 дүгээр тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 6184 дугаарт бүртгэсэн.
- “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан мэдээ ирүүлэх журам”-ыг боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 82 дугаар тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 6185 дугаарт бүртгэсэн.
- “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 83 дугаар тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 6186 дугаарт бүртгэсэн.
- “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”-ыг боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 84 дүгээр тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 6187 дугаарт бүртгэсэн.
- “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 85 дугаар тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 6188 дугаарт бүртгэсэн.
- “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, 162 дугаар тогтоолоор баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 6781 дугаарт бүртгэсэн.

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2024 оны 2 дугаар улирлын байдлаар СЗХ-нд бүртгүүлсэн нийт 65 барьцаалан зээлдүүлэх газраас 39.0 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 42 хувь буюу 16.0 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаарх мэдлэг олгох цахим сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн боловсролын HUB сургалтын төвтэй хамтран 2023 оны 3-р сарын 01-ний өдрөөс эхлэн тасралтгүй цахимаар зохион байгуулж байна.
- 2024 оны 2 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 2366 хүнийг бүртгэж, 1597 хүнд гэрчилгээ олгосон байна.



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Нийт хөрөнгө

300.7
тэрбум төгрөг



Санхүүгийн зах зээлийн төлөв

Нэг батлан даалтын
дундаж хэмжээ

30.8
сая төгрөг



Хүртээмжтэй байдал

Ирүүлсэн
хүсэлтийн тоо **5,441**



Бүтээгдэхүүн үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

10.0 тэрбум төгрөг

Тайлант үеийн ашиг

4.6 тэрбум төгрөг

Тогтвортой байдал




Чанаргүй батлан
даалтын эзлэх хувь

2.4%

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ




Сангийн нийт хөрөнгийн хэмжээ 300.7 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар буюу 43.1 тэрбум төгрөгөөр өссөн.




- Сангийн батлан даалтын үлдэгдэл 250.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.9 дахин буюу 165.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэв.
- Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.7 дахин буюу 288.4 тэрбум төгрөгөөр өсч 455.2 тэрбум төгрөгт хүрлээ.


Батлан даалт болон батлан даалттай зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Олгосон батлан даалтын тоо




Шинээр олгосон батлан даалтын дүн /тэрбум төгрөг/





Тайлант улиралд нийт 167.3 тэрбум төгрөгийн 5,429 батлан даалтыг шинээр гаргасан нь өмнөх оны мөн үеэс 56.0 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




НИЙТ БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ /тэрбум төгрөгөөр/





НЭГ БАТЛАН ДААЛТЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ

- Нэг зээлдэгчийн батлан даалтын үлдэгдэл дунджаар Улаанбаатар хотод 297.0 сая төгрөг, орон нутаг 26.5 сая төгрөг, улсын хэмжээнд 30.8 сая төгрөгт хүрэв.
- Бус нутгуудын хувьд Төвийн бүсэд нэг зээлдэгчид олгосон батлан даалтын дундаж үлдэгдэл хамгийн их буюу 30.4 сая төгрөг байна.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ


	Батлан даалт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо	Эзлэх хувь
2021.II	241	180	74.7%
2022.II	38	23	60.5%
2023.II	132	102	77.3%
2024.II	5,441	5,441	100.0%

Батлан даалт гаргуулахаар 5,441 хүсэлт ирснээс 5,441 хүсэлт нь зөвшөөрөгдсөн. Ирүүлсэн хүсэлтийн тоо нь өмнөх оны мөн үеэс 41.2 дахин өсжээ.



Тайлант улиралд олгосон нийт батлан даалтын 8.4 хувийг бөний болон жижиглэн худалдаа, 3.6 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 88.0 хувийг бусад салбар эзэлж байна. Бусад салбарын дийлэнх хэсгийг Шинэ хоршоо хөдөлгөөн болон ипотекийн батлан даалт бүрдүүлж байна.

Сангаас олгосон батлан даалтын 74.1 хувийг Төрийн банк, 8.3 хувийг Хаан банк, 7.0 хувийг Худалдаа хөгжлийн банк, 6.2 Капитрон банк, 1.9 хувийг Богд банк, 1.6 хувийг Голомт банк, 0.8 хувийг Хас банк, 0.1 хувийг Ариг банкнаас гаргасан зээл бүрдүүлсэн.




Сангаас олгож буй батлан даалтын эх үүсвэрийн 73.2 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөн, 16.6 хувийг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төслөөс, 8.2 хувийг ипотека, 0.6 хувийг банк, 0.6 хувийг Азийн хөгжлийн банкны эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих төслөөс, 0.7 хувийг бусад зээл болон төслүүдэд тус тус олгожээ.

- Гаргасан батлан даалтын дундаж хугацаа 80.2 сар буюу 6.7 жил байна.
- Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 84 сар буюу 7 жилээр өссөн үзүүлэлт юм.

80.2
CAP

Олгосон батлан даалтын хэмжээ



Батлан даалттай олгосон зээлийн хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 9.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагааны салбарт, 4.0 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 1.8 эрүүл мэндийн салбарт, 1.5 хувь нь тээврийн салбарт, 1.2 хувь нь үл хөдлөх хөрөнгийн салбарт, 0.8 хувь нь аялал жуулчлалын салбарт, 81.0 хувь нь бусад салбарт олгосон. Бусад салбарт олгосон батлан даалттай зээлийн ихэнх хэсгийг Шинэ хоршоо хөдөлгөөн болон ипотекийн батлан даалт эзэлж байна.



АШИГТ АЖИЛЛАГАА




Орлогын бүтэц



Зарлагын бүтэц



Нийт хөрөнгийн өгөөж





Сангийн нийт хөрөнгийн өгөөж 1.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан үзүүлэлт юм.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


Сангийн чанаргүй батлан даалтын үлдэгдэл 6.0 тэрбум төгрөгт хүрлээ.

Чанаргүй батлан даалтын үлдэгдэл
/тэрбум төгрөг/



Батлан даалтын нийт үлдэгдэлд эзлэх чанаргүй батлан даалтын хувь 2.4 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.6 пунктээр буурсан.

- Чанаргүй батлан даалтын үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 43.8 хувь нь боловсруулах үйлдвэр, 15.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 13.0 хувь нь аялал жуулчлалын салбарт, 9.9 хувь нь барилгын салбарт, 4.9 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 2.5 хувь нь боловсролын салбарт, 10.3 хувь нь бусад салбарт олгосон батлан даалтууд бүрдүүлж байна.







ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Зохицуулалттай этгээд

311



Салбарын төлөв

ҮХЭХЗ-ын зуучлалын хэлцэл

1,268.2
тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



98.7%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхлэгчид


Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ



2024 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 311 үл хөдлөх эд хөрөнгө зуучлал байгууллага (ҮХЭХЗБ)-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс өөрчлөлт ороогүй байна.



Нэг ҮХЭХЗБ дунджаар 1 брокер, 4 агенттай ажиллаж байна. Хамгийн олон агенттай ҮХЭХЗБ-ын агентын тоо 90 байна.

Брокер, агентуудын статистик
мэдээлэл

Нэг ҮХЭХЗБ дунджаар 1 брокер, 4 агенттай ажиллаж байна. Хамгийн олон агенттай ҮХЭХЗБ-ын агентын тоо 90 байна.

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тайланд хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗБ-уудын 464 хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ҮХЭХЗБ-уудын хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 94.5 хувийг иргэд, 3.9 хувийг хуулийн этгээд, үлдсэн 1.6 хувийг иргэн, хуулийн этгээд хамтран эзэмшиж байна.

НИЙТ ХӨРӨНГӨ

ҮХЭХЗБ-уудын нийт хөрөнгө 258.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 223.9 тэрбум төгрөг буюу 86.6 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 34.6 тэрбум төгрөг буюу 13.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 212.8 тэрбум төгрөг буюу 82.3 хувийг өр төлбөр, 45.7 тэрбум төгрөг буюу 17.7 хувийг эздийн өмч тус тус эзэлж байна.

ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	Мөнгөн дүн / тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	223.9	86.6%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	34.6	13.4%
ӨР ТӨЛБӨР	212.8	82.3%
ЭЗДИЙН ӨМЧ	45.7	17.7%



ҮХЭХЗБ-ын нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг тооцоход зах зээлийн 83.6 хувийг 15 байгууллага, 95.7 хувийг 64 байгууллага бүрдүүлж байна.

Нийт хөрөнгийн дүнгээр зах зээлд эзлэх хувийг авч үзвэл 90 сая ₮-с дээш хөрөнгөтэй 107 ҮХЭХЗБ-ын хөрөнгө зах зээлийн 97.9%-ийг, 60-с 90 сая ₮ хүртэл хөрөнгөтэй 26 ҮХЭХЗБ-ын байгууллага нийт зах зээлийнхээ 0.8 хувийг, 60 сая ₮ төгрөг хүртэл хөрөнгөтэй 178 байгууллагууд нийт зах зээлийн 1.4 хувийг тус тус бүрдүүлж байна.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Хөрөнгийн хэмжээ	Байгууллагын тоо	Зах зээлд эзлэх хувь
15 сая ₮ хүртэл	37	0.1%
30 сая ₮ хүртэл	144	0.8%
60 сая ₮ хүртэл	178	1.4%
90 сая ₮ хүртэл	204	2.1%
90 сая ₮ дээш	107	97.9%

АШИГТ АЖИЛЛАГАА



ROE болон ROA-ийн харгалзах интервал дахь ҮХЭХЗБ-ын тоо

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮХЭХЗБ–УУДЫН БАЙРШИЛ:



ОРОН НУТАГ 4



31.6%

СҮХБААТАР

97

26.4%

ХАН-УУЛ

82

11.1%

ЧИНГЭЛТЭЙ

34

10.7%

БАЯНГОЛ

33

18.9%

БАЯНЗҮРХ

58

1.3%

СОНГИНОХАЙРХАН 4

Нийт тусгай зөвшөөрөлтэй ҮХЭХЗБ–уудын 31.6 хувь нь Сүхбаатар, 26.4 хувь нь Хан–Уул, 18.9 хувь нь Баянзүрх, 10.7 хувь нь Баянгол, 11.1 хувь нь Чингэлтэй, 1.3 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус үйл ажиллагаа эрхэлж байгаа бол орон нутагт 4 байгууллага буюу 1.3 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР /ДАВХАРДСАН ТООГООР/




ШИГТГЭЭ

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй 311 ҮХЭХЗБ-аас ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд Чингэлтэй дүүрэгт орон сууцны 1 м.кв нь дунджаар 3,771,858.6 төгрөг буюу хамгийн өндөр дүнтэй борлуулагдсан бол Сонгинохайрхан дүүрэгт 2,741,521.8 төгрөг буюу хамгийн бага дүнтэй борлуулагдсан байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗБ-ЫН ТҮРЭЭС, ХӨЛСЛӨХ БОЛОН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН БОРЛУУЛАХ



ҮХЭХЗБ-ын ирүүлсэн мэдээгээр худалдсан үл хөдлөх хөрөнгийн хэлцлийн 88.8 хувийг орон сууц, 6.8 хувийг арилжааны, 4.2 хувийг үйлдвэрлэлийн, 0.2 хувийг газар тус тус эзэлж байна.

Худалдсан үл хөдлөх хөрөнгийн талбайн 56.6 хувийг газар, 38.5 хувийг орон сууцны, 3.9 хувийг арилжааны, 1.0 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлж байна.


Худалдсан үл хөдлөх хөрөнгийн арилжсан дүнгийн 88.2 хувийг орон сууц, 8.9 хувийг арилжааны, 2.3 хувийг газар, 0.6 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлж байна.

ҮХЭХЗБ-уудаар дамжуулан худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн нийт үнийн дүнгийн хэмжээгээр 50-аас доош м.кв бүхий үл хөдлөх хөрөнгө 38.9 хувийг, 51-ээс 100 м.кв хүртэлх 48.6 хувийг, 101-ээс 400 м.кв хүртэлх 8.0 хувийг, 401 м.кв-аас дээших талбайтай нь 4.5 хувийг тус тус эзэлж байна.


Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх, хөлслөхөд зуучилсан үл хөдлөх хөрөнгийн нийт үнийн дүнгийн хэмжээгээр 50-аас доош м.кв бүхий үл хөдлөх хөрөнгө 42.5 хувийг, 51-ээс 100 м.кв хүртэлх 41.7 хувийг, 101-ээс 400 м.кв хүртэлх 14.0 хувийг, 401 м.кв-аас дээших талбайтай нь 1.8 хувийг тус тус эзэлж байна.

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗБ нийт 5,601 хэлцлээр, 864.6 мянган м.кв талбай, 1,268.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан шилжүүлжээ.



Үл хөдлөх хөрөнгийн худалдаа



- Талбайн хэмжээ /мянган м.кв/
- Мөнгөн дүн /тэрбум төгрөг/


Худалдан борлуулсан үнийн дүнгийн хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 276.2 тэрбум төгрөгөөр буюу 27.8 хувиар өссөн байна.

Харин талбайн хувьд /м.кв/ өнгөрсөн оны мөн үеэс 157.0 м.кв буюу 22.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

ҮХЭХЗБ 3,768 хэлцлээр 314.2 мянган м.кв талбай, 103.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.


Хэлцлийн тоо



Талбайн хэмжээ /үнийн дүнгээр, тэрбум төгрөг/



Үл хөдлөх хөрөнгийн түрээс



- Талбайн хэмжээ /мянган м.кв/
- Мөнгөн дүн /тэрбум төгрөг/

Түрээсэлж, хөлсөлсөн нийн дүнгийн хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55.7 хувиар өссөн.

Мөн түрээсэлж, хөлсөлсөн талбайн хувьд 35.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- БНСУ, Сингапур, Япон улсын үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтнүүдэд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, эрх зүйн зохицуулалтын орчныг судалж, “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжлийн оролцогчдын ёс зүйн дүрэм”-ийг боловсруулсан.
- “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг шинэчлэн батлах тухай тогтоолын төслийн танилцуулгыг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу олон нийтээс санал авахаар Хорооны цахим хуудаст байршуулсан



ХАМТЫН АЖИЛЛАГАА

- “Монголын үл хөдлөх хөрөнгө удирдлагын академи”-аас “Реалторуудын дуу хоолой-2024” форумыг 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан ба тус арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хороо, СЭЗИС, олон улсын эрхтэй 100 гаруй реалторууд болон АНУ-д төвтэй Үндэсний реалторуудын холбоо, Япон улсын “JARECO” Мэргэжлийн холбоо, Ази номхон далайн бүс нутгийн төлөөллүүд оролцов.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Олон нийтийг соён гэгээрүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, залилан, луйвраас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2024 оны 4 дүгээр сарын 18–23-ны өдрүүдэд Хороо, “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ болон “Үнэгүй Групп” ХХК нарын хамтарсан 2 удаагийн уулзалтыг зохион байгууллаа.
- ҮХЭХЗБ-ын салбарын 2024–2027 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлох, замын зургийг шинэчлэн боловсруулах, олон улсын сайн туршлагыг судлах, мэргэжлийн холбоог чадавхжуулах зорилго бүхий уулзалтыг “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ-тай 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.
- “Үл хөдлөх эд хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран нэр бүхий 56 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын 58 эрх бүхий албан тушаалтанд 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр “Зайны болон газар дээрх хяналт шалгалт”, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр сургалт зохион байгуулав.
- Тайлант улиралд 6 удаагийн 273 оролцогчдыг хамруулсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын мэргэжилтэнд эрх олгох сургалт”-д салбарын зохицуулалттай холбоотой хууль журмын талаар сургалт хийв.



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

53

Хуулийн этгээд



Салбарын төлөв

453

Иргэн

Худалдан авсан үнэт
металл

148.2

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



74.0%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа явуулж буй
арилжаа эрхлэгч

Бодлого зохицуулалт




САЛБАРЫН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр тайлант үеийн байдлаар 53 хуулийн этгээд, 453 иргэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

53



111

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА
ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

122



220

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР
ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тайлант улиралд 53 хуулийн этгээдийн 85 хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 10.1 тэрбум төгрөг байна.


Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн 335 буюу 74.0 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 118 буюу 26.0 хувь нь орон нутагт байна.

Улаанбаатар хотод

74.0%

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ /БАЙРШЛААР/



- Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид ихэвчлэн орон нутагт, харин үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчид голчлон Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Тухайлбал үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн 63.3 хувь нь орон нутагт, 36.6 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ӨМНӨГОВЬ 4
ДАРХАН-УУЛ 8
ГОВЬ-АЛТАЙ 3
ХЭНТИЙ 1
УВС 2
БАЯНХОНГОР 10
ОРХОН 3

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

ХОВД 2
ДАРХАН-УУЛ 5
БАЯНХОНГОР 1

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч


БАЯНХОНГОР 13
СЭЛЭНГЭ 22
ТӨВ 14
ДАРХАН-УУЛ 10
ГОВЬ-АЛТАЙ 3
ӨМНӨГОВЬ 5
УВС 2
ДОРНОГОВЬ 1
ӨВӨРХАНГАЙ 1
ХОВД 4
ДОРНОД 1

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

ХУДАЛДСАН БОЛОН ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛ:

Тайлант оны эхнээс өссөн дүнгээр 928.2 кг үнэт металлыг 148.2 тэрбум төгрөгөөр худалдан авч, 651.4 кг үнэт металлыг 144.6 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын үнийн дүнгээс 2.3 дахин, худалдсан үнэт металлын үнийн дүнгээс 1.9 дахин тус тус өссөн байна.

ҮНЭТ МЕТАЛЛ ЭРХЛЭГЧИД БОЛОН ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ ХООРОНДЫН АРИЛЖАА



ХУДАЛДСАН БОЛОН ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН



**ХУДАЛДАЖ АВСАН
ҮНИЙН ДҮН**

11.7 тэрбум төгрөг

**ХУДАЛДАЖ
БОРЛУУЛСАН
ҮНИЙН ДҮН**

20.1 тэрбум төгрөг

Нийт 11.7 тэрбум төгрөгийн үнэт эдлэл худалдан авч, 20.1 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг борлуулсан байна.

ҮНЭТ МЕТАЛЛЫН БОРЛУУЛАЛТЫН ДҮН /ТЭРБУМ ₮/

**ХУДАЛДАЖ
АВСАН
ҮНИЙН ДҮН**

148.2 сая төгрөг

**ХУДАЛДСАН
ҮНИЙН ДҮН**

144.6 сая төгрөг

Нийт 148.2 тэрбум төгрөгийн үнэт металл худалдан авч, 144.6 тэрбум төгрөгийн үнэт металлыг борлуулсан байна.

ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	62.6	83.7%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	12.2	16.3%
ӨР ТӨЛБӨР	42.7	57.0%
ЭЗДИЙН ӨМЧ	32.2	43.0%

АШИГТ АЖИЛЛАГАА



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам” болон “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулахаар Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу олон нийтээс санал авахаар Хорооны цахим хуудаст байршуулсан.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2024 оны 5 дугаар сарын 21–25-ны өдрүүдэд Франц улсын нийслэл Парис хотод зохион байгуулсан "Хариуцлагатай ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээ" форумд Монгол Улсаас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон “Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр төсөл” (planetGOLD Mongolia)-ийн төлөөлөл оролцсон.
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан "MONGOLIAN JEWELLERY & METAL FORUM, EXPO 2024" арга хэмжээний үеэр Стандарт, хэмжил зүйн газар нь “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулсан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Монголбанкны Эрдэнэсийн сан, Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо нь 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хамтарсан уулзалт хийж, санал солилцон, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.
- Санхүүгийн зохицуулах хороо болон “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо” ГҮТББ хамтран “Mongolian jewellery & metal forum-2024”-г 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан.
- Хорооноос 2024 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Mongolian jewellery & metal forum-2024” арга хэмжээний үеэр “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын өнөөгийн байдал” сэдвээр мэдээлэл өгсөн.
- Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар, Санхүүгийн зохицуулах хорооны орон нутгийн төлөөлөгчид болон салбарын оролцогчдод зориулан Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, бүртгэл зөвшөөрөл, зайны болон газар дээрх хяналт шалгалт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл олгох цахим сургалтыг 2024 оны 2 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, нийт 104 оролцогч хамрагдсан.
- Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын 21 аймгийн ахлах мэргэжилтэн, улсын байцаагч нарт 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Хорооноос ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт анхаарах асуудлын талаар мэдлэг, мэдээлэл, зөвлөгөө өгөх цахим сургалтыг зохион байгуулсан.
- “Орон нутгийн санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт зөвлөгөөн”-д Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр “Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн хууль, эрх зүйн зохицуулалт, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага ба бусад зохицуулалт” сэдвээр мэдээлэл өгч хамтран ажилласан.
- Хорооноос “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо” ГҮТББ болон “Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр төсөл” (planetGOLD Mongolia)-тэй хамтран ҮМҮЧЭТХЭАЭ иргэдэд зориулсан сургалтыг Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ аймагт 2024 оны 5 дугаар сарын 06-24-ний өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 94 оролцогч хамрагдсан.
- Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний холбоотой байгуулсан сургалтын гэрээний дагуу эрх олгох 6 удаагийн сургалтаар 200 оролцогчид салбарын зохицуулалттай холбоотой хууль журмын талаар холбогдох хичээлийг заасан.



СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Хүсэлтийн тоо **20**

Туршигдаж буй
бүтээгдэхүүн **6**



Салбарын төлөв

A

4
шууд оролцогчид

4.8
тэрбум төгрөгийн арилжаа



Биржийн бус зах зээлийн
блокчэйн арилжааны систем



1,269
удаагийн хэлцлээр

255.4
тэрбум төгрөгийн арилжаа



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

P2P зээлийн үйлчилгээ



7,827

Харилцагчид

2.6

тэрбум төгрөгийн зээл

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ



4,345

Хөрөнгө
оруулагчид

264.7

сая төгрөгийн санхүүжилт

B2B зээлийн үйлчилгээ



51

Бүртгэлтэй харилцагчид

20.2

тэрбум төгрөгийн зээл

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Сэндбоксад ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 20* хүсэлт ирснээс 8 бүтээгдэхүүн сэндбокс орчинд орсон. Үүнээс 6 бүтээгдэхүүн 2024 оны 2 дугаар улирлын байдлаар туршигдаж байна.




B2B зээлийн үйлчилгээ

B2B зээлийн үйлчилгээ нь 2024 оны 1 дүгээр сард сэндбоксын орчинд орсон. Тус үйлчилгээ нь аж ахуй нэгжүүдийн богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээг хангах, байгууллагуудын харилцах дансанд буй илүүдэл нөөцийг эргэлтэд оруулах замаар зах зээл дэх эх үүсвэрийг үр ашигтайгаар ашиглах боломжийг олгох юм.



B2B зээлийн үйлчилгээ нь 2024 оны 2 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар тус платформд бүртгэлтэй 51 харилцагч байна. Платформоор нийт 20.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 14.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Мөн B2B зээлийн дундаж хүү 1.5 хувьтай байгаа бол хугацааны хувьд 14, 21, 28 гэсэн хоногуудтай байна.



Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021 оны 12 дугаар сард сэндрбокс орчинд орсон бөгөөд хадгаламжийн сертификат, итгэлцлийн үйлчилгээнд суурилсан мөнгөний захын хэрэгслүүдийг зуучлах үйлчилгээг нэмэлтээр туршиж байна.

Хадгаламжийн сертификат

2023 оны 9 дүгээр сараас 2024 оны 2 дугаар улирлыг хүртэлх байдлаар нийт 74.7 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Анхдагч арилжааны дүн Хоёрдогч арилжааны дүн

62.6 сая төгрөг **12.1** сая төгрөг

Итгэлцэл

2023 оны 10 дугаар сараас 2024 оны 2 дугаар улирлыг хүртэлх байдлаар нийт 2.4 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээг зуучилсан байна.

Анхдагч арилжааны дүн Хоёрдогч арилжааны дүн

1.9 тэрбум төгрөг **0.5** тэрбум төгрөг



Репо хэлцэл зуучлалын платформ дээр өнгөрсөн хугацаанд 41 зээлдүүлэгч, 32 зээлдэгч нийт 255.4 тэрбум төгрөгийн 1,269 удаагийн арилжаа хийсэн байна. Мөн мөнгөний зах нь тайлант улиралд 112 удаагийн 67.3 тэрбум төгрөгийн илүүдэл нийлүүлэлт, 22 удаагийн 7.4 тэрбум төгрөгийн илүүдэл эрэлттэй байсан. Репо хэлцлийн платформоор хийгдэж буй зээлийн дундаж хугацаа 33 хоног, харин репо зээлийн дундаж хүү 17.7 хувьтай байна.




Репо зээлийн дундаж хүү

17.7%



Репо зээлийн дундаж хугацаа

33 хоног




Мөнгөний захын ерөнхий үзүүлэлтүүд

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
2023.II	17	19	117	24,250,000,000	17.2	31
2024.II	19	25	158	41,300,000,000	17.7	33

Репо зээлийн тайлант улиралд 158 удаагийн репо хэлцэл биелж 41.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгджээ. Энэ улирлын биелсэн хэлцлийн тоо болон арилжааны дүнг түрүү жилийн мөн үетэй харьцуулахад биелсэн хэлцлийн тоо 41-ээр нэмэгдэж нийт арилжааны дүн 70 хувиар өссөн байна.

Мөнгөний захын хүүгийн түвшин ба арилжааны дүн, репо зээлийн хугацаагаар /сая төгрөгөөр/




Мөнгөний захын арилжааг бүтээгдэхүүнээр нь ангилан харвал 1 долоо хоногийн хугацаатай репо зээлийн хэлцэл бага хийгдсэн бол 4 долоо хоногийн хугацаатай репо зээл нь мөнгөний захын хамгийн эрэлттэй бүтээгдэхүүн байна.

P2P зээлийн үйлчилгээ

P2P зээлийн үйлчилгээ нь 2022 оны 12 дугаар сард сэндрбоксын орчинд орсон бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээг хөгжүүлэн хоёр дахь жилдээ туршиж байна.



P2P зээлийн үйлчилгээний харилцагчдын тоо



98.9%
зээлдэгч



1.1%

хөрөнгө оруулагч

Тус платформоор 7,827 харилцагч P2P зээлийн үйлчилгээг хүртжээ. Эдгээр харилцагчдын 1.1 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 98.9 хувь нь зээлдэгч байна.

Платформоор нийт 2.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 2.2 тэрбум төгрөгийн зээл нь эргэн төлөгдөж P2P зээлийн үлдэгдэл 377.3 сая төгрөг байна. Мөн олгосон зээлийн багцын 76.4 хувийг 3 сараас бага хугацаатай, 14.8 хувийг 4–6 сарын хугацаатай, 8.8 хувийг 7–9 сарын хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 41.2 хувийг 1 жилийн хугацаатай, 58.8 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.



1–12 сарын хугацаатай

Олгосон зээлийн дүн

2.6 тэрбум төгрөг

377.3 сая төгрөг
Зээлийн үлдэгдэл



Зээлийн ЖДХ 1.9%



Хэвийн
98.1%



Хугацаа хэтэрсэн
0.8%



Чанаргүй
1.1%

P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 98.1 хувь нь хэвийн, 0.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.1 хувь нь чанаргүй зээл байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 1.9 хувь байна.

Эмэгтэй



64.8%

Эрэгтэй



35.2%

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 64.8 хувь нь эмэгтэй, 35.2 хувь нь эрэгтэй байна. Харин нийт харилцагчдын 49.9 хувийг 18–35 насныхан, 34.7 хувийг 36–45 насныхан, 12.4 хувийг 46–55 насныхан, 3.0 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 61.9 хувь нь дээд, 4.2 хувь нь тусгай дунд, 29.3 хувь нь бүрэн дунд, 4.3 хувь нь дунд, 0.3 хувь нь бага боловсролтой байна.

НАСНЫ БҮЛГЭЭР

18–35 НАС



49.9%

36–45 НАС



34.7%

46–55 НАС



12.4%

55–ААС ДЭЭШ



3.0%

БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР



61.9%

ДЭЭД



4.2%

ТУСГАЙ
ДУНД

29.3%

БҮРЭН
ДУНД

4.3%

ДУНД



0.3%

БАГА



Хамтын санхүүжилтийн үйлчилгээ

Сэндбоксын орчинд 2 байгууллага хамтын санхүүжилтийн үйлчилгээ буюу краудфандинг үйлчилгээг туршиж байна. Үүнээс 2022 оны 12 дугаар сараас эхлэн эхний байгууллага бүтээгдэхүүн үйлчилгээгээ туршиж эхэлсэн бол удаах байгууллага нь 2023 оны 11 дүгээр сараас сэндбоксын орчинд орж урамшуулал, зээл, хувьцаа, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.



Төслийн дундаж хугацаа 20 хоног



Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн 27 төсөлд 2868 хөрөнгө оруулагч нийт 206.0 сая төгрөг хөрөнгө оруулснаас 197.5 сая төгрөгийн 20 урамшуулалт санхүүжилтийн төсөл амжилттай хэрэгжсэн. Төслүүдийн хувьд дунджаар нийт шаардлагатай санхүүжилтийг 70 хувийн биелэлттэйгээр босгосон.

Платформоор санхүүжилт босгосон эдгээр 27 төслийн 19 төсөл нь 1 сараас бага хугацаатай бөгөөд төслийн дундаж хугацаа 20 хоног байна.

Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн 12 төсөл нийтлэгдсэн бөгөөд нийт 1,475 оролцогчоос 47.7 сая төгрөгийн хандив босгосноос 11.5 сая төгрөгийг амжилттай хандивласан.

Зээлд суурилсан хамтын санхүүжилтийн 1 төсөл хэрэгжиж 2 хөрөнгө оруулагчаас 11.0 сая төгрөгийн санхүүжилт босгожээ.



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД НАСНЫ БҮЛГЭЭР

18–35 НАС



65.3%

36–45 НАС



22.6%

46–55 НАС



8.3%

55–ААС ДЭЭШ



3.8%

Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 65.3 хувь нь 18–35 нас, 22.6 хувь нь 36–45 нас, 8.3 хувь нь 46–55 нас, 3.8 хувь нь 55–аас дээш насныхан байна.

Блокчэйн арилжааны систем

Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем нь 2024 оны 11 дүгээр сараас эхлэн сэндрбоксын орчинд орсон. Биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн системийг нэвтрүүлснээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, цагийн хязгаарлалтгүй 24/7 гүйцэтгэх боломж бүрдэх юм.




Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем нь 2024 оны 4 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тайлант улирлын байдлаар тус платформоор нийт 47,862 ширхэг үнэт цаас 4.8 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан байна. Мөн бондын жигнэсэн дундаж хүү 21.2%-тай байна. Блокчэйн хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцсон 4 шууд оролцогч байна.

Блокчэйн системийн хоёрдогч арилжаанд 2 үнэт цаас гаргагч бонд гаргасан ба бондын санхүүжилтийг зээлийн багц нэмэгдүүлэхэд зарцуулахаар төвлөрүүлсэн байна.

Блокчэйн системийн арилжааны эзлэх хувь

Тайлант улиралд биржийн бус зах зээл дээр хийгдсэн нийт арилжааны 65 хувийг анхдагч зах зээлийн арилжаа, 34 хувийг уламжлалт хэлбэрээр гүйцэтгэсэн хоёрдогч зах зээлийн арилжаа, 1 хувийг блокчэйн систем дээр хийсэн хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.



- Анхдагч
- Хоёрдогч /уламжлалт/
- Хоёрдогч /блокчэйн/



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Зохицуулалтын орчныг сайжруулах ажлын хүрээнд:

“Азийн Хөгжлийн Банк (АХБ)”-ны санхүүжилттэй Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр төсөл (1) Монголын финтек, инновацын экосистемийг хөгжүүлэх замын зургийг боловсруулах, (2) Санхүүгийн хяналт, шалгалтад суптекийг нэвтрүүлэхэд шаардлагатай үнэлгээний болон бодлогын зөвлөмжийн тайланг боловсруулах зорилготойгоор 2025 оныг хүртэл хэрэгжиж буй бөгөөд төслийн үндсэн хэрэгжүүлэгчээр Санхүүгийн зохицуулах хороо, хамтран хэрэгжүүлэгчээр Монголбанк, Сангийн яам ажиллаж байна.

Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль хамтран “Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь” боловсруулж буй бөгөөд толь бичигт финтекийн салбарт хамаарах нэр томъёоны бүлгийг боловсруулан орууллаа.

Харилцаа холбооны зохицуулах хороо сэндбокс зохицуулалтыг нэвтрүүлэх гэж буйтай холбогдуулан туршлага солилцох уулзалтуудыг зохион байгууллаа.

Сэндбоксын орчныг олон нийтэд таниулах ажлын хүрээнд:

Зүүн өмнөд Азийн төв банкнуудын төлбөр тооцооны системийн хуралдаанд Сэндбоксын орчны талаарх танилцуулга илтгэл тавьсан;

Мэргэшсэн нягтлан бодогчдын институциас зохион байгуулсан төвийн бүсийн сургалтад “Финтек зах зээлийн хөгжил, зохицуулалтын орчин” сэдэвт сургалт, Авлигатай тэмцэх газрын албан хаагчдад “Сэндбокс зохицуулалт” сэдэвт сургалтыг орсон.

Сэндбоксын орчны оролцогчдод хяналт тавих, хамтран ажиллах ажлын хүрээнд:

2024 оны 2 дугаар улирлын байдлаар Сэндбокс орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 27 компанитай 69 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг мөн гүйцэтгэн ажиллаж байна.

Финтекийн хөгжил болон зохицуулалтын орчны талаарх цахим болон танхимын сургалт, уулзалтуудад тогтмол оролцож байна.



Сэндбоксод туршигдаж буй 6 бүтээгдэхүүн тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягтыг боловсруулан 7 хоног, сар, улирлын тайлан, мэдээг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

Сэндбоксод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ

Виртуал хөрөнгийн
үйлчилгээ үзүүлэгч

12



Салбарын төлөв

Харилцагчийн тоо


883,658



Хүртээмжтэй байдал

Гадаадын виртуал
хөрөнгийн өдрийн
арилжаа

4.6 тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Ашигт ажиллагаа



Нийт орлого

5.3 тэрбум төгрөг

Нийт ашиг

(0.5) тэрбум төгрөг

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ


--- ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТОО ---

Тус салбарт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) үйл ажиллагаа эрхэлж байна. ВХҮҮ-ийн тоо өмнөх улирлын мөн үеэс өсөлт, бууралт үзүүлээгүй.

ВХҮҮ-ийн үйл ажиллагааны чиглэлийн тоо /давхардсан тоогоор/



Дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөгөөр/




Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 161.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 102.4 тэрбум төгрөг буюу 1.6 дахин буурлаа.

--- ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ /НИЙТ АРИЛЖААГААР/ ---


ВХҮҮ-ийн зах зээлд эзэлж буй хувийг нийт арилжаагаар авч үзвэл 20 хувиас дээш 1 ВХҮҮ, 10–20 хувийг 1 ВХҮҮ, 10 хувиас доош хувийг 10 ВХҮҮ бүрдүүлж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




Давхардсан тоогоор 883,658 харилцагч ВХҮҮ-д бүртгэлтэй бөгөөд өмнө оны мөн үеэс 3.1 хувиар буурсан. Үүнээс 49.3 хувь буюу 435,520 нь баталгаажуулалт хийсэн харилцагчид бол тэдгээрийн 2.8 хувь буюу 24,736 нь арилжаанд идэвхтэй оролцдог болно.

БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД



БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИЙГ ТӨРЛӨӨР АНГИЛБАЛ:



Нийт баталгаажуулалт хийсэн 435,520 харилцагчийг ангилан харвал дотоодын иргэн 385,661 буюу 88.5 хувь, гадаадын иргэн 49,463 буюу 11.4 хувь, улс төрийн хамаарал бүхий этгээд 307 буюу 0.08 хувь, дотоодын хуулийн этгээд 89 буюу 0.02 хувь тус тус бүрдүүлжээ.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН АРИЛЖАА

Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр нийт 420.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн. Үүнээс:

- Гадаадын виртуал хөрөнгийн арилжаа 411.3 тэрбум төгрөг буюу 97.9 хувийг бүрдүүллээ.
- Нийт арилжааны 9.0 тэрбум төгрөг буюу 2.1 хувь нь дотоодын виртуал хөрөнгийн арилжаа эзэлж байна.



- Гадаадын виртуал хөрөнгийн арилжааны дүн /тэрбум төгрөг/
- Дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн /тэрбум төгрөг/



0.1

Дотоодын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа /тэрбум төгрөг/



4.6


Гадаадын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа /тэрбум төгрөг/

ВХҮҮ-ээр дамжуулан хийгдсэн гадаад виртуал хөрөнгийн дундаж арилжаа 4.6 тэрбум төгрөг, дотоод виртуал хөрөнгийн дундаж арилжаа 0.1 тэрбум төгрөг байна.




ВХҮҮ ДЭЭР АРИЛЖААЛАГДАЖ БҮЙ ДОТООД БОЛОН ГАДААД ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ТОО

12 ВХҮҮ-ээр дамжуулан нийт 724 виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаа бөгөөд үүнээс 6.2 хувь буюу 45 нь дотоодын, 93.8 хувь буюу 679 нь гадаадын виртуал хөрөнгө байна.



Нийт арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн 93.8 хувийг гадаадын виртуал хөрөнгө эзэлж байна.

Дотоодын виртуал хөрөнгө өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өсжээ.




АШИГТ АЖИЛЛАГАА

НИЙТ ХӨРӨНГӨ

Тайланд улиралд нийт хөрөнгө 65.9 тэрбум төгрөг бөгөөд үүний 47.2 тэрбум төгрөг буюу 71.6 хувийг эргэлтийн хөрөнгө, үлдсэн 18.7 тэрбум төгрөг буюу 28.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 45.4 тэрбум төгрөг буюу 68.9 хувийг өр төлбөр, 20.5 тэрбум төгрөг буюу 31.1 хувийг эздийн өмч эзэлж байна.


Хөрөнгө, эх үүсвэрийн ангилал	Мөнгөн дүн /тэрбум төгрөг/	Хөрөнгө болон эх үүсвэрт эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгө	47.2	71.6%
Эргэлтийн бус хөрөнгө	18.7	28.4%
Өр төлбөр	45.4	68.9%
Эздийн өмч	20.5	31.1%

Тайланд улиралд нийт 5.3 тэрбум төгрөгийн орлого олж 5.8 тэрбум төгрөг зарцуулж 0.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.





ХАВСРАЛТ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2022.И	2023.И	2024.И
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	4,841.0	10,998.6	11,305.7
ЗЗҮ/ДНБ	11.3%	20.8%	16.0%
Хөрвөх чадвар	2.3%	1.0%	1.4%
Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	113.7	429.8	185.9
Компанийн өрийн хэрэгслийн арилжаа /тэрбум төгрөг/	101.9	37.4	565.0
ХБҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/	58.0	42.2	61.6
Хөрөнгө оруулалтын сан /тэрбум төгрөг/	2.3	29.6	38.2
ТОП–20 индекс	32,795.68	36,899.16	44,385.18
MSE А индекс	12,384.65	16,216.23	17,223.73
MSE Б индекс	11,450.93	12,178.61	13,387.44
ХК–ийн тоо	314	321	311
ҮЦК–ийн тоо	56	52	52
ХААБ–ийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	722.1	494.9	657.4
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүн /тэрбум төгрөг/	–	1,223.5	6,155.3

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2022.И	2023.И	2024.И
Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	431.4	518.3	616.6
Даатгалын болон давхар даатгалын нийт хураамж /тэрбум төгрөг/	126.0	172.4	226.1
Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	48.5	53.4	70.0
Нөөц сан /тэрбум төгрөг/	185.9	244.2	290.6
Давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/	25.4	44.6	57.0
Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	9.2	1.1	19.8
Мэргэжлийн оролцогчид:			
Ердийн даатгал	15	15	16
Урт хугацааны даатгал	1	2	2
Давхар даатгал	1	1	1
Даатгалын төлөөлөгч	2,426	2,381	2,490
Даатгалын зуучлагч	62	64	62
Хохирол үнэлэгч	25	25	26
Актуарч	38	40	40
Аудитор	144	145	147
Аудитын компани	43	44	45

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2022.ИИ	2023.ИИ	2024.ИИ
Нийт хөрөнгө	3,182.7	3,945.9	5,756.6
Эргэлтийн хөрөнгө	3,079.6	3,815.1	5,490.5
Мөнгөн хөрөнгө	391.3	524.6	706.7
Богино хугацаат хөрөнгө оруулалт	16.8	34.9	77.0
Нийт зээл	2,497.8	3,107.5	4,590.5
Хэвийн зээл	2,225.5	2,766.9	4,169.7
Хугацаа хэтэрсэн зээл	98.1	103.1	137.9
Чанаргүй зээл	174.2	237.4	282.8
Зээлийн эрсдэлийн сан	130.5	177.5	212.4
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	18.6	21.4	29.6
Эргэлтийн бус хөрөнгө	103.1	130.7	266.1
Нийт өр төлбөр	3,182.7	1,477.7	2,581.9
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	300.3	449.3	884.8
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	395.1	428.2	871.9
Төслийн зээлийн санхүүжилт	20.7	33.3	19.5
Эзэмшигчдийн өмч	1,981.6	2,468.1	3,174.7
Хоёрдогч өглөг	70.5	75.9	66.2
Хувьцаат капитал	1,230.0	1,440.0	1,682.2
Хуримтлагдсан ашиг	632.9	889.3	1,329.2
ББСБ-ын тоо	527	522	549
Үүнээс: УБ хот	438	427	450
Хөдөө, орон нутаг	89	95	99
Харилцагчдын тоо	4,748,336	3,895,987	4,875,687
Нийт орлого	392.0	520.2	800.9
Хүүгийн орлого	308.6	439.1	712.9
Хүүгийн бус орлого	72.5	68.4	72.1
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	10.7	12.6	15.9
Нийт зардал	242.8	331.1	475.8
Хүүгийн зардал	43.2	60.7	167.7
Хүүгийн бус зардал	144.9	189.2	201.3
Болзошгүй эрсдэлийн зардал	33.6	50.7	46.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	3.7	4.9	60.6
Цэвэр ашиг	149.2	189.1	325.1

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2022.И	2023.И	2024.И
Нийт хөрөнгө	271.6	295.9	327.8
Эргэлтийн хөрөнгө	267.7	291.8	318.6
Мөнгөн хөрөнгө	35.2	52.2	65.8
Авлага	17.8	16.7	17.9*
Эргэлтийн бус хөрөнгө	3.9	4.1	9.2
Үндсэн хөрөнгө /цэврээр/	3.7	4.0	4.3
Биет бус хөрөнгө /цэврээр/	0.2	0.2	0.1
Нийт зээл	217.8	220.4	243.3
Хэвийн зээл	204.9	205.1	229.3
Хугацаа хэтэрсэн зээл	5.6	8.0	7.2
Чанаргүй зээл	7.2	7.3	6.8
Өр төлбөр	218.1	234.3	254.6
Нийт хадгаламж	189.4	203.9	242.3
Богино болон урт хугацаат өр төлбөр	14.1	13.9	7.8
Өөрийн хөрөнгө	53.5	61.6	73.2
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	26.1	27.2	28.6
Хоршоологчдын өмч	27.2	34.2	44.3
Хуримтлагдсан орлого /алдагдал/	7.9	12.0	19.0
Нийт орлого	30.1	30.3	36.0
Хүүгийн орлого	28.3	28.7	33.7
Үйл ажиллагааны бус орлого	1.1	1.1	0.9
Үйл ажиллагааны бусад орлого	0.6	0.5	1.4
Нийт зарлага	25.0	27.5	30.2
Хүүгийн зардал	16.1	17.4	19.3
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	1.1	1.5	0.9
Үйл ажиллагааны зардал	7.3	8.1	9.3
Үйл ажиллагааны бус зардал	0.0	0.1	0.0
Цэвэр орлого	5.0	2.8	5.8
ХЗХ–дын тоо	200	192	181
УБ ХЗХ–дын тоо	110	101	92
Орон нутаг ХЗХ–дын тоо	90	91	89
Гишүүдийн тоо	72,566	71,184	74,186
УБ ХЗХ–дын тоо	114	101	95
Орон нутаг ХЗХ–дын тоо	91	90	89
Гишүүдийн тоо /мянга/	74,966	69,962	73,293

Тайлбар: Сангийн сайдын 2024 оны А/49 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу боловсруулсан болно.

*Бусад санхүүгийн хөрөнгө, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага болон зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлагын нийлбэрээр тооцов.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2022.И	2023.И	2024.И
Нийт хөрөнгө	258.9	257.6	300.7
Батлан даалтын үлдэгдэл	82.7	85.5	250.9
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	2.2	2.6	1.1
Чанаргүй	10.3	9.4	6.0
Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл	162.3	166.8	455.2
Үүнээс: Хугацаа хэтэрсэн	5.0	4.7	1.7
Чанаргүй	23.0	20.1	18.1
Үндсэн үйл ажиллагааны орлого	4.9	5.7	10.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	1.0	1.4	5.4
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	3.9	4.3	4.6
Олгосон батлан даалтын тоо	21	97	5,429
Олгосон батлан даалтын дүн	6.9	21.4	167.3
Үүнээс: Иргэдэд	0.0	0.6	134.1
Аж ахуй нэгжид	6.9	20.8	33.2
Үүнээс: Хөдөө аж ахуй	0.0	0.3	1.2
Үйлдвэрлэл	0.1	8.7	5.9
Бөөний болон жижиглэн худалдаа	1.0	9.5	14.0
Үйлчилгээ	5.8	2.3	12.1
Батлан даалт гаргасан дундаж хугацаа /сараар/	85.3	164.2	80.2
Батлан даалт авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо	38	132	5,441
Үүнээс: Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	23	102	5,441

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2023.II	2024.II
ҮХЭХЗ–ын байгууллагын тоо	311	311
Брокерын тоо	324	324
Агентын тоо	1,269	1340
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХЭХ–ийн талбайн хэмжээ /мянган м.кв/	707.6	864.6
Худалдаж, худалдан авч, шилжүүлсэн ҮХЭХ–ийн үнэ /тэрбум төгрөг/	992.0	1,268.2
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлслөсөн ҮХЭХ–ийн талбайн хэмжээ /мянган м.кв/	232.1	314.2
Түрээслүүлж, түрээсэлж, хөлслүүлж, хөлслөсөн ҮХЭХ–ийн үнэ /тэрбум төгрөг/	66.3	103.2

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд	2023.И	2024.И
Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо	49	53
Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тоо	71	111
Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн тоо	251	220
Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн тоо	139	122
Худалдан авсан үнэт металлын бохир жин /кг/	236.8	928.2
Худалдан авсан үнэт металлын нийт үнэ /тэрбум төгрөг/	41.3	148.2
Худалдсан үнэт металлын бохир жин /кг/	259.6	651.4
Худалдсан үнэт металлын нийт үнэ /тэрбум төгрөг/	49.0	144.6
Худалдан авсан эдлэлийн нийт үнэ /тэрбум төгрөг/	3.8	11.7
Худалдсан эдлэлийн нийт үнэ /тэрбум төгрөг/	4.1	20.1

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

/Тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2023.II	2024.II
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо	12	12
Харилцагчийн тоо	912,238	883,658
Үүнээс: Идэвхтэй арилжаа хийдэг	85,312	24,736
Баталгаажуулалт хийсэн	458,205	435,520
Дотоодын виртуал хөрөнгийн тоо	41	45
Дотоод виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	263.9	161.5
Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр хийгдсэн дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн /өссөн дүнгээр/	27.2	9.0
Хувь нийлүүлсэн хөрөнгө	24.9	24.9
Нийт хөрөнгө	50.6	65.9
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	(7.0)	(0.5)



